



УВС АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг үндэслэн Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон бүрэн эрхийн хүрээнд хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлан



Төрөөс хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэх чиглэлээр авч хэрэгжүүлсэн бодлогын хэрэгжилт үр дүнтэй байна.

Төрөөс хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэх чиглэлээр авч хэрэгжүүлсэн бодлогын хэрэгжилт, үр дүн



**УВС АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН
ТУШААЛ**

2022 оны 05 сарын 05 өдөр

Дугаар А/20

Улаангом

Аудитын тайлан батлах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйл 6.3 дахь хэсэг, 29 дүгээр зүйлийн 29.4 дэх хэсэг, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2018 оны А/207 дугаар “Эрх шилжүүлэх тухай” тушаалын 5 дугаар хавсралт, 2022 оны А/29 дүгээр тушаалаар батлагдсан “Төрийн аудитын байгууллагын 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө”-г тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Төрөөс хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэх чиглэлээр авч хэрэгжүүлсэн бодлогын хэрэгжилт, үр дүн”-д хийсэн гүйцэтгэлийн аудитын тайланг /УВА-2022/20/-19-ШТА-ГА/ хавсралтаар баталсугай.

2. Аудитын тайланг Үндэсний аудитын газрын Аудитын гуравдугаар газар, аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурал, Засаг дарга, Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газарт тус тус хүргүүлсүгэй.

3. Гүйцэтгэлийн аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аудитын менежер М.Бат-Амгалан, ахлах аудитор Б.Авирмэд нарт даалгасугай.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

М.БАТСУУРЬ

0200100033

АГУУЛГА

Тайлан бэлтгэсэн:	Агуулга	3
Дарга, тэргүүлэх аудитор М.Батсуурь	Товчилсон үгийн тайлал	6
Аудитын менежер М.Бат-Амгалан	Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй, Үндсэн мэдээлэл	7 9
Ахлах аудитор Б.Авирмэд	Бүлэг 1. Төрөөс хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэх чиглэлээр авч хэрэгжүүлсэн бодлогын баримт бичиг, төрийн байгууллагуудын бүтэц, чиг үүргийн уялдаа холбоо хангагдсан байна.	11
Аудитор А.Нанжидмаа Р.Аюуш	1. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэх чиглэлээр төрөөс хэрэгжүүлж буй хөтөлбөрүүд нь орон нутгийн дунд хугацааны тогтвортой хөгжлийн зорилттой уялдаатай байна.	11
2022 оны 5 дугаар сар	1.1. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэх дунд, богино хугацааны бодлогыг орон нутагт хөгжлийн бодлого, төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлсэн байна.	11
	1.2. Хөдөлмөрийн зах зээлийн эрэлт хэрэгцээг тодорхойлсон судалгааг 2015, 2020 онуудад хийсэн байна.	12
Аудитын тайлан, дүгнэлттэй холбоотой асуудлаар нэмж тодруулах, асууж лавлах зүйл байвал 7045-3721, 7045-3799 дугаарын утсаар харилцана уу.	1.3. Хөдөлмөрийн зах зээлийн эрэлт хэрэгцээг тодорхойлсон судалгааг 2015, 2020 онуудад хийсэн байна.	13
	2. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэх бодлогыг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийн эх үүсвэрийг үндэслэлтэй төлөвлөсөн байна.	13
	2.1. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэхэд шаардлагатай санхүүжилтийг үндэслэлтэй тооцсон байна.	13
Хаяг: Увс аймаг дахь Төрийн аудитын газар Улаангом сум 3-р баг, Аймгийн Засаг даргын тамгын газрын байр	2.2. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэх бодлогыг хэрэгжүүлэхэд шаардагдах санхүүжилтийн эх үүсвэрийг оновчтой тодорхойлж, тусгахад аймгийн ХХҮГ санал хүргүүлсэн байна.	14
	2.3. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэх бодлогыг цаг тухайд нь үр дүнтэй хэрэгжүүлэхэд шаардагдах санхүүгийн нөөцийг дутуу хуваарилсан байна.	15
	3. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих салбарын төрийн байгууллагуудын чиг үүрэг харилцан уялдаатай байна.	16
	3.1. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэх чиглэлээр төрийн байгууллагуудын үйл ажиллагааны төлөвлөгөө уялдаж байна.	16
	3.2. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжихдээ бүс нутгийн онцлогт тохирсон зохицуулалт, хяналтын арга хэмжээг 2017 оноос бусад онуудад аваагүй байна.	17

	3.3. Хөдөлмөр эрхлэлтийн салбар зөвлөл нь хууль, дүрэмд заасан чиг үүргээ хэрэгжүүлсэн байна.	18
	3.4. Бодлогын хэрэгжилтийг бодитой тайлагнаж төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт хийж үр дүнг тооцсон байна.	19
	Бүлэг 2. Төрөөс хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажилгүйдлийг бууруулах, ажлын байрыг нэмэгдүүлэх чиглэлээр хэрэгжүүлсэн үйл ажиллагааны үр дүн, хөрөнгийн зарцуулалт үр ашигтай байна.	20
	4. Хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээнд хамаарах үйл ажиллагаа зохих үр нөлөөтэй байна.	20
	4.1. Хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээнд хамаарах үйл ажиллагаа зохих үр нөлөөтэй байна.	20
	4.2. Нэгдсэн бүртгэл, мэдээллийн системийн зарим модуль ажиллахгүй, мэдээлэл боловсруулалт удаан байна.	21
	4.3. Хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээнд 2016-2021 онд нийт 124,750.4 мянган төгрөг зарцуулж санхүүгийн тайланд тусгасан байна.	22
	5. Засгийн газраас хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажилгүйдлийг бууруулах, ажлын байр нэмэгдүүлэх чиглэлээр хэрэгжүүлсэн арга хэмжээ үр нөлөөтэй байна.	23
	5.1. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэх, ажилгүйдлийг бууруулах чиглэлээр гадаад болон дотоодын зээл, тусламж, бүх төрлийн сан, олон улсын байгууллагуудын санхүүжилттэй төсөл, хөтөлбөрийн хэрэгжилт тодорхой хэмжээнд үр дүнтэй байна.	23
	5.2. Төсөл, хөтөлбөрийн хэрэгжилт, санхүүжилт, үр дүнг бодитой тайлагнаж, үнэлсэн байна.	26
	5.3. Эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих талаар зохих, үр дүнтэй арга хэмжээ аваагүй байна.	33
	6. Хөгжлийн бэрхшээлтэй иргэн ажиллуулаагүй ААН, байгууллагын төлбөрийг 2018-2021 онуудад төвлөрүүлээгүй, ХЭДС-ийн хөрөнгийг үр дүнтэй зарцуулсан байна.	33
	6.1. ХЭДС-ийн орлогыг хуульд заасны дагуу бүрэн төвлөрүүлээгүй байна.	34
	6.2. ХЭДС-ийн хөрөнгийг хууль, журмын дагуу зарцуулсан байна.	35
	7. Мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагаас хөдөлмөрт бэлтгэх үйл ажиллагаа үр нөлөөтэй хэрэгжсэн байна.	36

	7.1. МБСДС-аас 2016-2021 онуудад санхүүжилт аваагүй байна.	36
	7.2. Мэргэжлийн боловсролын, байгууллагын санхүүжилт үр нөлөөтэй байна.	36
	8. "Ковид-19" цар тахлын үед хөдөлмөр эрхлэлтийн талаар төрөөс авч хэрэгжүүлсэн арга хэмжээ	38
	8.1. Цар тахлын үед аж ахуй эрхлэгчдийн үйл ажиллагааг сэргээх хөтөлбөр хэрэгжүүлсэн байна.	38
	8.2. Цар тахлын үед аж ахуй эрхлэгчдийн үйл ажиллагааг сэргээх хөтөлбөр хэрэгжүүлсэн байна.	39
	8.3. Цар тахлын үеийн сөрөг нөлөөллөөс зорилтот бүлгийн хөдөлмөр эрхлэлт, ажлын байрыг хамгаалахаар хэрэгжүүлж буй арга хэмжээний үр дүнд хяналт тавиагүй байна.	40
	8.4. Цар тахлын улмаас хөдөлмөр эрхлэлтийн салбарт гарсан өөрчлөлт, статистик тоо мэдээг үнэн бодитой гаргасан байна.	42
	Дүгнэлт	44
	Холбогдох байгууллагын санал	45
	Аудитын газраас өгөх тайлбар	47
	Зөвлөмж	48

Товчилсон үгийн тайлал:

1	ҮАГ	Үндэсний аудитын газар
2	МУЗГ	Монгол улсын Засгийн газар
3	ХЭДС	Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан
4	ХХҮЕГ	Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар
5	АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
6	ХХҮГ	Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар
7	ОНТҮГ	Орон нутгийн төсөвт үйлдвэрийн газар
8	ХЭҮЗ	Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөл
9	МБСДС	Мэргэжлийн боловсрол, сургалтыг дэмжих сан
10	ГОУХАН	Германы олон улсын хамтын ажиллагааны нийгэмлэг
11	ХАБЭА	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй
12	ШХА	Швейцарын хөгжлийн агентлаг
13	ААН	Аж ахуй нэгж
14	УИХ	Улсын Их Хурал
15	ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
16	ЗДТГ	Засаг даргын тамгын газар
17	ХЗЗ	Хөдөлмөрийн зах зээл
18	АМЧБО	Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох
19	ЭМНДХ	Эрүүл мэнд нийгмийн даатгалын хэлтэс
20	НҮБ	Нэгдсэн үндэсний байгууллага
21	ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
22	НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
23	ААНОАТ	Аж ахуй нэгжийн орлогын албан татвар
24	ХХОАТ	Хувь хүний орлогын албан татвар

АУДИТЫН ЗОРИЛТ, ХАМАРСАН ХҮРЭЭ, АРГА ЗҮЙ

1. Аудит хийсэн үндэслэл, бүрэн эрх:

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1-д заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд УИХ-ын Төсвийн байнгын хорооны 2021 оны 06 дугаар тогтоол, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2022 оны А/12 дугаар тушаалаар баталсан Төрийн аудитын байгууллагын 2022 онд гүйцэтгэх аудитын төлөвлөгөө, Увс аймаг дахь Төрийн аудитын газрын 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу гүйцэтгэлийн аудитыг хийж гүйцэтгэв.

2. Аудитын зорилт:

Төрөөс хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэх чиглэлээр авч хэрэгжүүлсэн бодлогын хэрэгжилт, үр дүнг тооцож, дүгнэлт, зөвлөмжийг боловсруулж, холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулахад аудитын зорилго чиглэсэн.

Аудитын зорилгыг хангахын тулд аудитыг дараах дэд зорилтын хүрээнд гүйцэтгэв. Үүнд:

1. Төрөөс хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэх чиглэлээр авч хэрэгжүүлсэн бодлогын баримт бичиг мөн төрийн байгууллагуудын бүтэц, чиг үүргийн уялдаа холбоо хангагдсан эсэх
2. Төрөөс хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажилгүйдлийг бууруулах, ажлын байрыг нэмэгдүүлэх чиглэлээр хэрэгжүүлсэн үйл ажиллагааны үр дүн, хөрөнгийн зарцуулалт үр ашигтай байгаа эсэх

3. Аудитын хамарсан хүрээ:

Аудитад Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн хүрээнд Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 320 дугаар тогтоолоор баталсан Төрөөс хөдөлмөр эрхлэлтийн талаар баримтлах бодлогын баримт бичигт тусгасан төсөл, хөтөлбөр зорилго, зорилт, арга хэмжээг хариуцан хэрэгжүүлэх, биелэлтийн явц, үр дүнг тооцон тайлагнах, үнэлж дүгнэх үүрэг хүлээсэн хөдөлмөр эрхлэлтийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага, Улаангом Политехник коллеж, Хөдөлмөр эрхлэлтийн аймгийн зөвлөлийн 2016-2021 оны үйл ажиллагаа, "Ковид-19" цар тахлын үед хөдөлмөр эрхлэлтийн талаар төрөөс авч хэрэгжүүлсэн арга хэмжээтэй холбоотойгоор Нийгмийн даатгалын хэлтэс, Татварын хэлтэс, арилжааны банкнуудын холбогдох үйл ажиллагааг хамрууллаа.

4. Аудитын арга зүй:

Аудитыг АДБОУС 100, 300, 3000-3100, Монгол Улсын Төрийн аудитын стандарт MNS 6817-5:2020 Гүйцэтгэлийн аудитын зарчим, MNS 6817-7:2020 Гүйцэтгэлийн аудитын стандарт, "Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам", "Гүйцэтгэлийн аудитын заавар, аргачлал"-ын дагуу аудитын зорилго,

зорилт, асуудлын шинжилгээний асуултад хариулт өгөхөд шаардагдах бүх төрлийн нотлох баримтыг цуглуулж, баримтжуулан, тэдгээрийг нягтлан шалгах, дүн шинжилгээ, харьцуулалт, тулган баталгаажуулалт хийх арга зүйг ашиглав.

5. Аудит хийсэн багийн бүрэлдэхүүн:

Аудитыг Увс аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор М.Батсуурь хянан удирдаж, үе шатны чанарын хяналтыг аудитын менежер М.Бат-Амгалан хэрэгжүүлж, ахлах аудитор Б.Авирмэд, аудитор А.Нанжидмаа, Р.Аюуш нар төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу хийж гүйцэтгэлээ.

6. Аудит хийх явцад тохиолдсон хүндрэл

Тус аудитын гүйцэтгэлийн шатны ажлыг 2022 оны 03 дугаар сарын 15-ны өдрөөс эхлэхээр төлөвлөсөн боловч Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2 дахь заалтын дагуу 2022 оны 03 дугаар сарын 25-ны өдрийг дуустал багийн гишүүд 2-3 Төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудит хийсэн. Үүнээс шалтгаалан гүйцэтгэлийн шатны ажлыг 2022 оны 03 дугаар сарын 29-ний өдрөөс эхлүүлсэн. Аудит хийх хугацаанд Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.5 дахь заалтын дагуу Орон нутгийн 2021 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл, Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нөхөн сонгуульд нам, эвсэл, нэр дэвшигчийн мөрийн хөтөлбөр, хандивын тайланд дүгнэлт өгөх аудитуудыг зэрэгцүүлэн хийж гүйцэтгэлээ.

Дээрх шалтгаануудаас тус аудитыг богино хугацаанд хийж гүйцэтгэсэн болно.

ҮНДСЭН МЭДЭЭЛЭЛ

Хөдөлмөр эрхлэлт нь хөгжлийн бодлогын тэргүүлэх чиглэлийн гол үндэс болохын хувьд УИХ, МУЗГ-аас хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэх чиглэлээр төрөөс баримтлах бодлого, хууль, эрх зүйн баримт бичгийг батлан, төсөл, хөтөлбөрүүдийг хэрэгжүүлж байна.

Монгол Улсад хөдөлмөр эрхлэлтийн харилцааг Хөдөлмөрийн тухай хууль, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хууль, Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хууль, Нийгмийн даатгалын тухай хууль, Гадаадад ажиллах хүч илгээх, гадаадаас ажиллах хүч, мэргэжилтэн авах тухай хууль, Нийгмийн даатгалын сангаас ажилгүйдлийн тэтгэмж олгох тухай хууль, Нийгмийн халамжийн тухай хууль болон бусад хууль тогтоомжоор зохицуулж байна.

МУЗГ-ын 2016 оны 320 дугаар тогтоолоор “Төрөөс хөдөлмөр эрхлэлтийн талаар баримтлах бодлого”-ыг баталсан нь хөдөлмөр эрхлэлтийг дэмжих бодлогын ерөнхий хүрээ болсон байна.

Бодлогын хэрэгжилтийг хангахдаа хөдөлмөр эрхлэлтийг дэмжих чиглэлээр дараах төсөл, хөтөлбөрүүдийг төлөвлөн хэрэгжүүлсэн байна. Үүнд:

Хүснэгт-1

№	2016 онд хэрэгжүүлсэн хөтөлбөрүүд	2017-2020 онуудад хэрэгжүүлсэн хөтөлбөрүүд	2021 онд хэрэгжүүлсэн хөтөлбөрүүд
1	Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөх үйлчилгээг дэмжих хөтөлбөр	Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөх үйлчилгээ	Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөх үйлчилгээ
2	Ажилд зуучлах үйлчилгээ	Ажилд зуучлах үйлчилгээ	Ажилд зуучлах үйлчилгээ
3	Аж ахуй эрхлэх, бичил бизнесийг дэмжих хөтөлбөр	Хөдөлмөрт бэлтгэх, хөдөлмөр эрхлэлтийн ур чадвар олгох хөтөлбөр	Хөдөлмөрт бэлтгэх хөтөлбөр
4	Хөдөлмөр эрхлэлтийн ур чадвар олгох, ажлын байрыг дэмжих хөтөлбөр		
5	Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр	Ажлын байрыг дэмжих хөтөлбөр	Цар тахлын үед аж ахуй эрхлэгчдийн үйл ажиллагааг сэргээх хөтөлбөр
6	Хөгжлийн бэрхшээлтэй иргэний ажлын байрыг дэмжих хөтөлбөр	Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр	Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр
7	Малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр	Малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр	Хөгжлийн бэрхшээлтэй иргэний хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр
8	Нийтийг хамарсан ажил зохион байгуулах хөтөлбөр	Хөгжлийн бэрхшээлтэй иргэний ажлын байрыг дэмжих хөтөлбөр	Ахмадын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр
9	Ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээ төсөл	Ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээ төсөл	Хүүхэд хамгаалагч төсөл
10	Жижиг зээл	Жижиг зээл	Жижиг зээл

Эх сурвалж: Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар

Бодлогын нэгдүгээр үе шат нь 2016-2020 онд хэрэгжиж дууссан бөгөөд УИХ-ын 2021 оны 52 дугаар тогтоолоор “Алсын хараа-2050” урт хугацааны хөгжлийн

бодлогын баримт бичгийг баталсантай холбогдуулан Төрөөс хөдөлмөр эрхлэлтийн талаар баримтлах бодлогын баримт бичгийг МУЗГ-ын 2021 оны 314 дүгээр тогтоолоор хүчингүй болгожээ.

Бодлогын нэгдүгээр үе шат буюу 2016-2020 оны хөдөлмөр эрхлэлт, ажилгүйдлийн үзүүлэлтийг доорх хүснэгтэд он тус бүрээр дэлгэрэнгүй харууллаа.

Увс аймгийн хөдөлмөр эрхлэлт, ажилгүйдлийн зарим үзүүлэлт

Хүснэгт-2

Ерөнхий мэдээлэл	2016	2017	2018	2019	2020
15 ба түүнээс дээш настай эдийн засгийн идэвхтэй хүн амын тоо	54593	55228	55722	54893	55523
Ажиллах хүч	36580	38230	36436	34872	34667
Ажиллах хүчнээс гадуурх хүн ам	12571	11801	13732	16224	14270
Ажиллагчдын тоо	31381	33261	32712	32568	30788
Ажилгүй иргэдийн тоо	5200	4969	3723	2304	3879
Бүртгэлтэй ажилгүйчүүдийн тоо	994	901	632	739	872
Ажлын шинэ байрны тоо	709	1300	1202	1454	1200
Ажилгүйдлийн түвшин, /хувиар/	14.2	13.0	10.2	6.6	11.2
Хөдөлмөр эрхлэлт /хувиар/	63.8	66.5	65.2	63.7	62.9
Ажиллах хүчний оролцооны түвшин	74.4	76.4	72.6	68.2	70.8

Эх сурвалж: Статистикийн хэлтэс

Статистикаас харахад ажилгүй иргэдийн тоо 2017-2019 онуудад буурч 2020 онд өссөн үзүүлэлттэй байна.

Бүлэг 1. Төрөөс хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэх чиглэлээр авч хэрэгжүүлсэн бодлогын баримт бичиг, төрийн байгууллагуудын бүтэц, чиг үүргийн уялдаа холбоо хангагдсан байна.

1. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэх чиглэлээр төрөөс хэрэгжүүлж буй хөтөлбөрүүд нь орон нутгийн дунд хугацааны тогтвортой хөгжлийн зорилттой уялдаатай байна.

1.1. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэх дунд, богино хугацааны бодлогыг орон нутагт хөгжлийн бодлого, төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлсэн байна.

Увс аймгийн Засаг даргын 2016-2020 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөрт Хөдөлмөр эрхлэлттэй холбоотой дараах 5 заалтыг тусгаж хэрэгжүүлэн ажилласан байна.

1.1.1 Ажилгүй иргэдийн судалгааг нарийвчлан гаргаж, ажлын багтаамж ихтэй үйлдвэрлэл, үйлчилгээг дэмжин хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлж, мал багатай өрхийг дэмжин малжуулах хөтөлбөрийг хэрэгжүүлж, 200-аас доошгүй шинэ, 500-аас доошгүй байнгын болон улирлын ажлын байр бий болгоно.

1.1.2 Ажилгүй иргэн, ажилгүйдэлд өртөж болзошгүй иргэн, ажил олоход хүндрэлтэй иргэдийн орлогыг нэмэгдүүлэхэд чиглэсэн хөтөлбөрүүд хэрэгжүүлж, жил бүр 500-аас доошгүй иргэнийг түр ажлын байраар хангана.

1.1.3 Аймгийн хөдөлмөрийн чуулган зохион байгуулж, хөдөлмөр эрхлэлтийн эрэлтийн судалгааг 2 жил тутам 1 удаа хийж, хэрэгцээнд нийцсэн мэргэжилтэй ажилтан бэлтгэх бодлогыг хэрэгжүүлнэ.

1.1.4 Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн дэд хөтөлбөрийг хэрэгжүүлж, эрүүл, аюулгүй ажлын байрыг дэмжиж, хөдөлмөрийн тухай хуулийн биелэлтийг 2 жилд 1 удаа төрийн болон аж ахуйн нэгж байгууллагуудад үзлэг хэлбэрээр зохион байгуулна.

1.1.5 Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжин ажлын байрыг нэмэгдүүлэх, бий болсон ажлын байрыг тогтвортой хадгалах бодлого баримтална.

Увс аймгийн Засаг даргын 2021-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт дараах 4 заалт тусгагдан хэрэгжилтийг зохион байгуулан ажиллаж байна.

2.6.2. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн талаарх хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангаж, ажлын байрны осол гэмтлээс урьдчилан сэргийлэх,

2.6.3. Хөдөлмөр эрхлэлтийн үйл ажиллагааны үр дүнд суурилсан санхүүжилтийн арга хэлбэрийг нэвтрүүлэн, хөтөлбөр, бүтээн байгуулалтын томоохон төслүүдийн үр дүнд хувийн хэвшил, жижиг, дунд үйлдвэрлэл, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих замаар ажилгүйдлийг бууруулж, жилд 1200 ажлын байр бий болгох,

2.6.4. Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төв, сургалтын байгууллагуудыг түшиглэн хэрэгцээнд нийцсэн чадварлаг мэргэжилтэй ажилтан бэлтгэж, ажилд зуучлах,

2.6.5. Иргэдийг хөдөлмөрийн зах зээлийн талаарх мэдээллээр хангаж, албан бус хөдөлмөр эрхлэлтийн бүртгэл, мэдээллийг сайжруулах.

"Увс аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл"-д хөдөлмөр эрхлэлтийн чиглэлээр дараах 6 заалт тусгагдаж хэрэгжилтийг зохион байгуулан ажиллаж байна.

2.3.4 Хөгжлийн бэрхшээлтэй хүн, ахмад настанд ээлтэй, хүртээмжтэй орчин нөхцөлийг бүрдүүлж, хөдөлмөр эрхлэх боломжоор хангана.

2.6.1. Хөдөлмөрийн болон хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн хууль тогтоомжийг хэрэгжүүлж, үйлчилгээний хүртээмж, цалин хөлс, урамшууллын оновчтой хэлбэрийг мөрдөнө.

2.6.2. Хөдөлмөр эрхлэлтийн үр дүнд суурилсан санхүүжилтийн арга хэлбэрийг нэвтрүүлэн, ажилгүйдлийг бууруулах, ажлын байрыг нэмэгдүүлэх арга хэмжээг хэрэгжүүлнэ.

2.6.3. Оюуны хөдөлмөрийг дэмжсэн цахим, зайн ажлын байрыг нэмэгдүүлнэ.

2.6.4. Албан бус хөдөлмөр эрхлэлтийн бүртгэл, мэдээллийг сайжруулна

3.3.1. Залуучуудын бүтээлч санаачилга, гарааны болон бичил, жижиг, дунд бизнесийг дэмжинэ.

Түүнчлэн аймгийн нийгэм, эдийн засгийг хөгжүүлэх үндсэн чиглэлд хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх ажлын байрыг дэмжих чиглэлээр жил бүр тодорхой арга хэмжээнүүдийг тусган аймгийн ИТХ-аар батлуулан биелэлтийг тооцон ажиллаж байна. 2016-2021 оны аймгийн нийгэм, эдийн засгийг хөгжүүлэх үндсэн чиглэлд тусгагдсан арга хэмжээний тоо биелэлтийг хүснэгтээр харуулбал дараах байдалтай байна.

Хүснэгт-3

Он	2016	2017	2018	2019	2020	2021	Дүн
Зорилтын тоо	1	2	10	3	3	2	21
Хэрэгжилтийн хувь	70	100	97	90	100	100	92.8

Эх сурвалж: Аймгийн ЗДТГ

1.2. Хөдөлмөрийн зах зээлийн эрэлт хэрэгцээг тодорхойлсон судалгааг 2015, 2020 онуудад хийсэн байна.

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.10.1 дэх заалтад “Хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, нийлүүлэлтийн урт болон богино хугацааны төлөв байдлыг судлах, хэтийн тооцоо боловсруулах”, 30 дугаар зүйлийн 30.1.1 дэх заалтад “Хөдөлмөр эрхлэлтийн мэдээ, мэдээлэлд дүн шинжилгээ, хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, нийлүүлэлт, төлөв байдлын болон ажиллах хүчний ур чадварын хэрэгцээний судалгааг тодорхой давтамжтайгаар хийх, мэргэшсэн байгууллагаар гэрээгээр гүйцэтгүүлэх, хэтийн тооцооллын загвар боловсруулах”, Төрөөс хөдөлмөр эрхлэлтийн талаар баримтлах бодлогын 4.1.2-г “Хөдөлмөрийн зах зээлийн мэдээлэл, судалгаанд үндэслэн зохистой хөдөлмөр эрхлэлт, хөгжлийн уялдааг хангасан бодлого боловсруулах, хэрэгжүүлэх чадавхыг бэхжүүлэх” гэж заасан байна.

Энэ хүрээнд 2015 онд ШХА-ийн санхүүжилтээр “Увс аймгийн хөдөлмөрийн зах зээлийн судалгаа”-г хийж 2016-2018 оны хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, ажилгүй иргэдийн сургалтын хэрэгцээ, ажил олгогчийн ажилтанд тавих шаардлага, тулгарч буй хүндрэл бэрхшээл зэргийг тооцсон байна.

Түүнчлэн аймгийн “Хөдөлмөрийн зах зээлийн эрэлт нийлүүлэлтийн судалгаа” хийж үнэлгээ, дүгнэлт, зөвлөмж гаргах зорилгоор аймгийн Засаг даргын 2019 оны А/383 дугаар захирамжаар 30 хүний бүрэлдэхүүнтэй судалгааны багийг байгуулсан байна.

Аймгийн хөдөлмөрийн зах зээлийн дунд хугацааны /2020-2022/ ажиллах хүчний эрэлт нийлүүлэлтийг салбар, ажил мэргэжлээр тодорхойлж, боловсролын болон хөдөлмөр эрхлэлтийн бодлого боловсруулагч, шийдвэр гаргагчид, мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллага, аж ахуйн нэгж, байгууллага, иргэдийг мэдээллээр хангахад судалгааны зорилго чиглэсэн байна.

Судалгаанд 510 аж ахуйн нэгж, байгууллага, 651 хувиараа хөдөлмөр эрхлэгч, 991 малчин өрх, 898 ажилгүй иргэд, 860 ажил эрхэлж буй залуучууд, Улаангом политехник коллежийн 440 суралцагчдыг тус тус хамруулжээ.

Увс аймгийн хөдөлмөрийн зах зээлийн эрэлт нийлүүлэлтийн судалгааг ШХА-ийн санхүүжилтээр Германы "GFA" зөвлөх компанийн хэрэгжүүлж байгаа Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төслийн санхүүгийн болон мэргэжлийн туслалцаатайгаар гүйцэтгэж аймгийн хөдөлмөрийн зах зээлийн дунд хугацааны эрэлт нийлүүлэлтийн тоо хэмжээ, гарч болох чанарын өөрчлөлтийн талаарх мэдээллийг нэгтгэн, дүгнэлт, зөвлөмж боловсруулж товхимол хэлбэрээр хэвлэсэн байна.

1.3. Орон нутагт бодлогын баримт бичгийг боловсруулахад бүх талуудын оролцоог хангасан байна.

Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 320 дугаар тогтоолоор "Төрөөс хөдөлмөр эрхлэлтийн талаар баримтлах бодлого"-ыг орон нутагт хэрэгжүүлэн ажилласан ба тусгайлсан бодлогын бичиг баримт боловсруулж хэрэгжүүлээгүй байна.

Харин Увс аймгийн Засаг даргын 2016-2020, 2021-2024 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөр, "Увс аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл", аймгийн нийгэм, эдийн засгийг хөгжүүлэх жил бүрийн үндсэн чиглэлд тодорхой зорилт арга хэмжээг тусган хэрэгжүүлэн ажилласан байна.

Дээрх дунд болон богино хугацааны бодлогын бичиг баримтуудыг боловсруулахдаа Хөгжлийн бодлого, төлөвлөлт түүний удирдлагын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэгт "Хөгжлийн бодлого, төлөвлөлтөд дараах зарчмыг баримтална", 5.1.13 дахь заалтад "Бүх талын оролцоог хангасан байх" гэж заасныг хэрэгжүүлэн аймгийн ИТХ-аар батлуулсан байна. Үүнд:

- Иргэд олон нийт
- Холбогдох болон бусад төрийн байгууллагууд
- Сумдын санал
- ИТХ-ын төлөөлөгчдийн саналыг авч нэгтгэн орон нутгийн богино болон дунд хугацааны бодлогын бичигт тусган хэрэгжүүлж ажилласан байна.

2. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэх бодлогыг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийн эх үүсвэрийг үндэслэлтэй төлөвлөсөн байна.

2.1. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэхэд шаардлагатай санхүүжилтийг үндэслэлтэй тооцсон байна.

Аймгийн ХХҮГ нь хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэхэд шаардлагатай санхүүжилтийг ажилгүйдлийн түвшин, бүртгэлтэй ажил хайгч, хөдөлмөрийн насны хүн ам, өмнөх онд хэрэгжүүлсэн төсөл хөтөлбөрт хамрагдсан байдал зэргийг харгалзан жил бүр тооцож дараа жилийн төсвийн төслийг боловсруулж ХХҮЕГ-т хүргүүлсэн байна.

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2016-2021 оны төсвийн төсөлд тусгагдсан шаардлагатай санхүүжилтийн хэмжээ болон үндэслэлийг хүснэгтээр харуулбал дараах байдалтай байна.

Хүснэгт-4

Тайлант он	Хөтөлбөр	Арга хэмжээ	Санхүүжилт /мян.төг/	Шаардагдах хөрөнгийн үндэслэлтэй
2016	6	19	1,302,440.0	- Хөдөлмөрийн насны хүн амын тоо 5030 - Ажилгүйдлийн түвшин 14.2% - Ажил хайгч 1156 - Бүртгэлтэй ажилгүйчүүдийн тоо 981
2017	6	19	978,096.0	- Хөдөлмөрийн насны хүн амын тоо 50752 - Увс аймгийн ажиллах хүчний оролцооны түвшин 76.4% - Хөдөлмөр эрхлэлтийн түвшин 66.5% - Ажилгүйдлийн түвшин 13% - Бүртгүүлсэн ажил идэвхтэй хайж байгаа ажилгүй хүний тоо 1134 болж - Ажилгүйдлийн түвшин 13%
2018	6	19	2,075,360.0	- Хөдөлмөрийн насны хүн амын тоо 51000 - Ажиллах хүчний оролцооны түвшин 72.6% - Хөдөлмөр эрхлэлтийн түвшин 65.2% - Ажилгүйдлийн түвшин 10.2% - Бүртгүүлсэн ажил идэвхтэй хайж байгаа ажилгүй хүний тоо 596 - Аймгийн ажилгүйдлийн түвшин 10.2
2019	6	19	2,233,206.0	-Хөдөлмөрийн насны хүн амын тоо 49900 - Ажиллах хүчний оролцооны түвшин 68.2% - Хөдөлмөр эрхлэлтийн түвшин 63.7% - Ажилгүйдлийн түвшин 6.6% - Бүртгүүлсэн ажил идэвхтэй хайж байгаа ажилгүй хүний тоо 701
2020	6	19	1,595,465.0	-Хөдөлмөрийн насны хүн амын тоо 51000 - Ажилгүйдлийн түвшин 11.2% - Бүртгүүлсэн ажил идэвхтэй хайж байгаа ажилгүй хүний тоо 611 - Ажилгүйдлийн түвшин 11.2%
2021	5	17	1,935,808.0	-Хөдөлмөрийн насны хүн амын тоо 52907 - Ажилгүйдлийн түвшин 3.97% - Бүртгүүлсэн ажил идэвхтэй хайж байгаа ажилгүй хүний тоо 794 - Ажилгүйдлийн түвшин 3.97%

Эх сурвалж: Аймгийн ХХҮГ

2.2. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэх бодлогыг хэрэгжүүлэхэд шаардагдах санхүүжилтийн эх үүсвэрийг оновчтой тодорхойлж, тусгахад аймгийн ХХҮГ санал хүргүүлсэн байна.

Хөгжлийн бодлого, төлөвлөлт түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1 дэх хэсэгт “Төрийн захиргааны төв болон холбогдох төрийн захиргааны байгууллага нь өөрийн эрхлэх асуудлын хүрээнд үйл ажиллагаа явуулдаг төсвийн болон нутгийн захиргааны байгууллага, төрийн өмчийн болон

хувийн хэвшлийн аж ахуй нэгжийн саналыг нэгтгэн боловсруулж, жил бүрийн 01 дүгээр сарын 15-ны дотор үндэсний хөгжлийн бодлого, төлөвлөлтийн болон санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад ирүүлнэ” гэж заасны дагуу аймгийн ХХҮГ нь саналаа ХХҮЕГ-т хүргүүлсэн байна.

Аймгийн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан нь төв сангаасаа санхүүждэг бөгөөд орон нутгийн түвшинд санхүүжилтийн эх үүсвэр бүрдүүлдэггүй байна. Харин эргэн төлөх нөхцөлтэй санхүүгийн дэмжлэгийн эргэн төлөлтийн орлого болон хөгжлийн бэрхшээлтэй иргэн ажиллуулаагүйн төлбөрийг төв сандаа төвлөрүүлдэг байна. Үүнээс шалтгаалан Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэх бодлогыг хэрэгжүүлэхэд шаардагдах санхүүжилтийн эх үүсвэрийг тодорхойлж тусгахад санал хүргүүлэхээс өөрөөр шууд шийдвэрлэх боломжгүй байна.

2.3. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэх бодлогыг цаг тухайд нь үр дүнтэй хэрэгжүүлэхэд шаардагдах санхүүгийн нөөцийг дутуу хуваарилсан байна.

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.8 дахь хэсэгт “Үндэсний зөвлөл дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ”, 28.8.4 дэх заалтад “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн төсвийг хуваарилах асуудлыг хэлэлцэж, зөвлөмж гаргах, тус сангийн орлого, зарлагын байдалд хяналт тавих” гэж заасны дагуу тухайн онд хэрэгжих төсөл хөтөлбөр, санхүүгийн нөөцийг хуваарилсан тогтоол шийдвэрийг гаргасан байна. Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн тогтоолын жагсаалтыг хүснэгтээр харуулбал дараах байдалтай байна.

Хүснэгт-5

Он	Тогтоол
2016	Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн 2015 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн есдүгээр дүгээр тогтоол
2017	"Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрүүдийг батлах тухай" Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн 2017 оны 01 дүгээр сарын 27-ны өдрийн нэгдүгээр тогтоол
2018	"Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрүүдийг батлах тухай" Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн 2018 оны 01 дүгээр сарын 19-ний өдрийн нэгдүгээр тогтоол
2019	"Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих 2019-2020 оны хөтөлбөрүүдийг батлах тухай" Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн 2019 оны 01 дүгээр сарын 14-ний өдрийн нэгдүгээр тогтоол
2020	"Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төсөл хөтөлбөрт нэмэлт өөрчлөлт оруулах, төсөв батлах тухай" Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн 2020 оны 01 дүгээр сарын 31-ний өдрийн 01 дүгээр тогтоолын гуравдугаар хавсралт
2021	"Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих 2021-2022 оны хөтөлбөрүүдийг батлах тухай" Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн 2021 оны 02 дугаар сарын 09-ний өдрийн нэгдүгээр тогтоол

Эх сурвалж: Аймгийн ХХҮГ

Увс аймгийн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн батлагдсан төсөв болон хуваарилагдсан санхүүжилт, хэрэгжүүлэхээр төлөвлөсөн хөтөлбөр, төсөл, үйлчилгээний тоо, хамрагдвал зохих хүний тоог хүснэгтээр харуулбал дараах байдалтай байна.

Хүснэгт-6

Он	Батлагдсан төсөв /мян.төг/	Ирсэн санхүүжилт /мян.төг/	Зөрүү /мян.төг/	Хэрэгжүүлэхээр төлөвлөсөн хөтөлбөр, төсөл, үйлчилгээний тоо	Хамрагдвал зохих хүний тоо
2016	1,006,416.0	798,100.0	-208,316.0	1 үйлчилгээ, 7 хөтөлбөр, 1 төсөл	3493
2017	1,001,460.0	870,209.0	-131,251.0	2 үйлчилгээ, 6 хөтөлбөр	3201
2018	1,031,728.2	983,500.0	-48,228.2	2 үйлчилгээ, 6 хөтөлбөр, 1 туршилтын төсөл	4045
2019	1,259,920.0	1,184,000.0	-75,920.0	2 үйлчилгээ, 6 хөтөлбөр	3308
2020	933,469.1	774,089.5	-159,379.6	2 үйлчилгээ, 5 хөтөлбөр, 1 төсөл	3773
2021	775,887.3	760,775.4	-15,111.9	2 үйлчилгээ, 5 хөтөлбөр, 2 төсөл	3538

Эх сурвалж: Аймгийн ХХҮГ

Аудитад хамрагдсан онуудад төлөвлөснөөс 15,111.9 - 208,316.0 мянган төгрөгөөр санхүүжилт дутуу хуваарилагдаж ирсэн байна. Үүнээс шалтгаалан хэрэгжүүлэхээр төлөвлөсөн хөтөлбөр, төсөл, үйлчилгээ бүрэн хэрэгжихгүй байх эрсдэл үүсэж байна.

3. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих салбарын төрийн байгууллагуудын чиг үүрэг харилцан уялдаатай байна.

3.1. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэх чиглэлээр төрийн байгууллагуудын үйл ажиллагааны төлөвлөгөө уялдаж байна.

Увс аймгийн дунд болон богино хугацааны бодлогын бичиг баримтыг боловсруулахдаа хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэх чиглэлээр холбогдох төрийн байгууллагуудын саналыг авч тусгасан байна. Тухайлбал: ХХҮГ нь 2016 онд 1, 2017 онд 3, 2018 онд 2, 2019 онд 3, 2020 онд 2, 2021 онд 3, нийт 14 санал хүргүүлснээс бодлогын бичиг баримтад нэгтгэн томьёолж 6 заалт тусгагдсан байна.

Хууль тогтоомжоор хүлээсэн чиг үүрэг, бодлогын бичиг баримтад тусгагдсан зорилт, тухайн жилийн үйл ажиллагааны төлөвлөгөөгөө хэрэгжүүлэх үүднээс холбогдох төрийн байгууллагууд хамтран ажилласан байна. Тухайлбал: ХХҮГ нь 2016-2021 онд үйл ажиллагааны төлөвлөгөөндөө тусган аймаг, сумдын ЗДТГ, Мэргэжлийн хяналтын газар, Улаангом тохижилт үйлчилгээ ОНТҮГ, Улаангом политехник коллеж зэрэг газруудтай хамтарч хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэх чиглэлээр тодорхой арга хэмжээнүүдийг зохион байгуулсан байна. Хамтарч зохион байгуулсан арга хэмжээний тоо хэрэгжилтийг хүснэгтээр харуулбал дараах байдалтай байна.

Хүснэгт-7

Он	Хамтарч үйл ажиллагаа явуулсан төрийн байгууллагын тоо	Зохион байгуулсан арга хэмжээний тоо	Хэрэгжилтийн дундаж хувь
2021	6	9	100
2020	3	4	77.6
2019	4	14	94
2018	3	10	86.9

2017	6	9	83.3
2016	3	7	88.1
Дундаж	4.2	8.8	88.3

Эх сурвалж: Аймгийн ХХҮГ

Хүснэгтээс харахад жилд дунджаар 4 төрийн байгууллагатай хамтарч 9 арга хэмжээ зохион байгуулсан ба 88.3 хувьтай хэрэгжүүлсэн байна.

3.2. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжихдээ бүс нутгийн онцлогт тохирсон зохицуулалт, хяналтын арга хэмжээг 2017 оноос бусад онуудад аваагүй байна.

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3 дахь заалтад “Алслагдсан болон эдийн засгийн сул хөгжилтэй бүс нутагт хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтыг дэмжих, эсхүл төр, хувийн хэвшлийн түншлэлд суурилсан зарчмаар хөрөнгө оруулах”, Төрөөс хөдөлмөр эрхлэлтийн талаар баримтлах бодлогын 4.1.3-т “Хөрөнгө оруулалт болон зээл, зээлийн батлан даалт, санхүүгийн түрээс, дэмжлэгтэй холбогдсон арга хэмжээг бүсчлэн ялгавартай хэрэгжүүлэх замаар алслагдсан болон эдийн засгийн сул хөгжилтэй бүс, орон нутагт зохистой хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх” гэж заасан ч 2017 оноос бусад онуудад бүс нутгийн онцлогт тохирсон төсөл хөтөлбөрийг хэрэгжүүлээгүй байна.

Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн 2017 оны 03 дугаар сарын 21-ний өдрийн 03 тогтоолоор Орон нутаг, нийслэлийн онцлог, хэрэгцээнд нийцүүлсэн зорилтот төсөл батлагдсан байна.

Тус зорилтот төслийн шалгаруулалт зохион байгуулах “Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газарт төсөл сонгон шалгаруулах ажлын хэсгийг байгуулан, аймаг, нийслэл, дүүргээс ирүүлсэн төслүүдийг хүлээн авч, зохих хууль тогтоомжийн дагуу сонгон шалгаруулах ажлыг зохион байгуулж, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын шийдвэрээр баталгаажуулна. Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар нь батлагдсан төслүүдийг хэрэгжүүлэгч байгууллагатай хамтран ажиллах гэрээ байгуулж, санхүүжүүлэн, хэрэгжилт, үйл ажиллагаанд нь хяналт тавьж ажиллана” удирдамжийг ирүүлсэн байна.

Аймгийн хөдөлмөр эрхлэлтийн салбар зөвлөл нь зөвлөлийн дүрмийн 2.1.2-т “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хууль, төрийн бодлого, хөтөлбөрийн хэрэгжилтийг тухайн орон нутагт зохион байгуулах, түүнчлэн хөдөлмөр эрхлэлтийн аймгийн бодлого, хөтөлбөр, төсөл боловсруулах, хэрэгжүүлэх талаар санал боловсруулж Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, холбогдох байгууллагуудад тавьж шийдвэрлүүлэх” гэсэн заалтын хүрээнд “Орон нутгийн онцлогт тохирсон” жимс, жимсгэнэ тариалах нөхөрлөлийг хамруулах хүсэлтийг ХХҮЕГ-т хүргүүлсэн байна.

Төслийн сонгон шалгаруулалтыг ХХҮЕГ зохион байгуулсан ба санхүүжилт нь аймгийн ХХҮГ-аар дамжаагүй байна.

Тус төсөл сонгон шалгаруулалтад Улаангом сумын 1-р багийн “Чандмань эрдэнийн нөхөд” нөхөрлөл тэнцэж, 150.0 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэгт хамрагдаж ажилгүй 20 өрхийг зохион байгуулалтад оруулан газар тариалан эрхлүүлэх замаар ажлын байраар хангасан байна. Төслийн хүрээнд 1900 метр торон хашаатай 20 га талбайд гүний 3 худаг гаргуулан элит сортын 20.0 мянган чацарганын суулгасан байна.

3.3. Хөдөлмөр эрхлэлтийн салбар зөвлөл нь хууль, дүрэмд заасан чиг үүргээ хэрэгжүүлсэн байна.

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1 дэх хэсэгт “Хөдөлмөр эрхлэлтийн байгууллагын тогтолцоо нь хөдөлмөр эрхлэлтийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, хөдөлмөр эрхлэлтийн үндэсний болон аймаг, нийслэл, дүүргийн зөвлөл, аймаг, нийслэл, дүүргийн хөдөлмөр эрхлэлтийн байгууллага, сум, хорооны хөдөлмөр эрхлэлтийн ажилтан /хөдөлмөрийн алба/, хөдөлмөрийн биржээс бүрдэнэ”, 28 дугаар зүйлийн 28.1 дэх хэсэгт “Засгийн газар, ажил олгогч болон ажилтны эрх, хууль ёсны ашиг сонирхлыг төлөөлөн хамгаалах улсын хэмжээний байгууллагын төлөөлөл бүхий Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний болон аймаг, нийслэл, дүүргийн зөвлөлийг байгуулж, ажиллуулна” гэж заасны дагуу аймгийн хөдөлмөр эрхлэлтийн салбар зөвлөлийг байгуулсан ч аймаг, нийслэл, дүүргийн зөвлөлийн эрх үүргийг тусгаагүй байна.

Харин хуулийн 28 дугаар зүйлийн 28.3 дахь хэсэгт “Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн дүрмийг ажил олгогч болон ажилтны эрх, хууль ёсны ашиг сонирхлыг төлөөлөн хамгаалах улсын хэмжээний байгууллагатай зөвшилцөн Засгийн газар, хөдөлмөр эрхлэлтийн аймаг, нийслэл, дүүргийн зөвлөлийн дүрмийг Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөл батална” гэж заасны дагуу ХЭҮЗ-ийн 2017 оны 02 дугаар тогтоолоор “Аймаг, нийслэл, дүүргийн зөвлөлийн дүрэм”-ийг баталсан байна.

Дүрмийн 2.1.4-д “Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлөөр батлагдсан хөтөлбөрүүд болон орон нутгийн онцлогтой хөтөлбөр төслийг хэлэлцэн батлах, хэрэгжилтийг нь удирдан зохицуулах, биелэлтэд нь хяналт тавих” гэж заасны дагуу аймгийн Хөдөлмөр эрхлэлтийн салбар зөвлөл нь ХЭҮЗ-ийн батлагдсан тухайн жилийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төсөл, хөтөлбөрийг хэлэлцэн баталсан байна.

“Төсөл, хөтөлбөрийн төсвийн хуваарийг батлахдаа ХХҮГ-ын танилцуулга, саналд тулгуурлан сумдын хүн амын тоо, хөдөлмөр эрхлэлт, ажилгүйдлийн түвшнийг харгалзан үзсэн байна.

Түүнчлэн хэрэгжсэн төсөл хөтөлбөрийн биелэлтэд салбар зөвлөл нь 2020, 2021 онуудад хяналт тавьсан байна.

“Аймаг, нийслэл, дүүргийн зөвлөлийн дүрэм”-ийн 2.2.2-т “Аймаг, нийслэл, дүүрэгт хөдөлмөр эрхлэлтийн талаар баримтлах бодлого, холбогдох хөтөлбөрүүд, түүнчлэн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан болон аймаг, нийслэлийн төсвөөс санхүүжүүлэх орон нутгийн онцлогтой хөтөлбөрийг боловсруулан батлуулах ажлыг санаачлан зохион байгуулах” гэж заасан ч орон нутгийн онцлогтой хөтөлбөрийг батлуулаагүй байна. Цаашид дүрэмд заасан чиг үүргийг хэрэгжүүлж орон нутгийн онцлогтой хөтөлбөр боловсруулж аймгийн ИТХ-аар батлуулахыг холбогдох албан тушаалтнуудад зөвлөлөө.

Дүрмийн 3.7-д “Зөвлөлийн гишүүд хөдөлмөрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас тогтоосон хэмжээгээр гишүүний оролцоог харгалзан зөвлөлийн нарийн бичгийн даргыг хамруулан урамшуулал олгоно. Урамшуулал болон зөвлөлийн үйл ажиллагааны зардлыг аймаг, нийслэл, дүүргийн хөдөлмөр эрхлэлтийн байгууллагын төсөвт тусган Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас санхүүжүүлнэ” гэж заасны дагуу салбар зөвлөлийн гишүүдэд хуралдаанд оролцсон ирц, идэвхийг харгалзан урамшуулал олгосон байна.

3.4. Бодлогын хэрэгжилтийг бодитой тайлагнаж төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт хийж үр дүнг тооцсон байна.

Аудитад хамрагдсан онуудад бодлогын бичиг баримтад тусгагдсан зорилтуудыг ХХҮГ нь жилийн ажлын төлөвлөгөөндөө тусган хэрэгжүүлж биелэлтийг тооцсон байна. ХХҮГ-ын жилийн ажлын төлөвлөгөөнд тусгагдсан зорилт, арга хэмжээний тоо, биелэлтийг хүснэгтээр харуулбал дараах байдалтай байна.

Хүснэгт-8

Он	Зорилтын тоо	Арга хэмжээний тоо	Биелэлтийн хувь
2021	3	14	96.6
2020	2	7	98.0
2019	3	20	100.0
2018	4	16	98.7
2017	4	12	89.7
2016	1	5	80.0
Дундаж	2.8	12.3	93.8

Эх сурвалж: Аймгийн ХХҮГ

Судалгаанаас харахад жил бүр 1-4 зорилтын хүрээнд 5-20 арга хэмжээг төлөвлөж 80-100 хувь биелүүлсэн гэж дүгнэгдсэн байна.

Аймгийн ХХҮГ нь Төрөөс хөдөлмөр эрхлэлтийн талаар баримтлах бодлогын хэрэгжилтэд хяналт, шинжилгээ, үнэлгээ хийх үүрэг хууль, тогтоомжоор хүлээгээгүй байна. Харин ХЭҮЗ-ийн баталсан төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтэд жил бүр хяналт хийж үр дүнг тооцсон байна. Хяналт хийсэн дүнг хүснэгтээр харуулбал дараах байдалтай байна.

Хүснэгт-9

№	Санхүүгийн дэмжлэг олгосон он	Хяналт хийсэн он	Хяналт хийсэн хөтөлбөрийн тоо	Хяналт хийсэн тоо	Үр дүн
1	2016	2017	4	1	2016 онд хэрэгжсэн 4 хөтөлбөрийн 492.0 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэгт 197 иргэн хамрагдаж, хөтөлбөрүүдийн хэрэгжилт 90 хувьтай байжээ.
2	2017	2018	5	1	2017 онд хэрэгжсэн 5 хөтөлбөрийн 495.0 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэгт 119 иргэн хамрагдаж хөтөлбөрүүдийн хэрэгжилт 78 хувьтай байна
3	2018	2019	5	1	2018 онд хэрэгжсэн 5 хөтөлбөрийн 454.0 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэгт 138 иргэн хамрагдаж хөтөлбөрүүдийн хэрэгжилт 93 хувьтай байна
4	2019	2020	5	1	2019 онд хэрэгжсэн 5 хөтөлбөрийн 752.0 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэгт 116 иргэн хөтөлбөрүүдийн хэрэгжилт 90 хувьтай байна
5	2020	2021	4	1	2020 онд хэрэгжсэн 4 хөтөлбөрийн 587.0 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэгт 166 иргэн хамрагдаж хөтөлбөрүүдийн хэрэгжилт 98 хувьтай байна.
6	2021	2022	4	1	2021 онд хэрэгжсэн хөтөлбөрт 108 иргэн хамрагдаж 366.0 сая төгрөг зарцуулсан хяналт хийгдэж байна
Дүн				6	

Эх сурвалж: Аймгийн ХХҮГ

Судалгаанаас харахад жил бүр 4-5 хөтөлбөрийг хамруулан тогтмол хяналт хийж үр дүнг тооцож хэвшсэн байна. Хяналтад давхардсан тоогоор 27 хөтөлбөрийг хамруулсан ба 23 дүгнэлт гаргаж 23 зөвлөмж өгч биелэлтийг тооцож ажилласан байна.

Бүлэг 2. Төрөөс хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажилгүйдлийг бууруулах, ажлын байрыг нэмэгдүүлэх чиглэлээр хэрэгжүүлсэн үйл ажиллагааны үр дүн, хөрөнгийн зарцуулалт үр ашигтай байна.

4. Хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээнд хамаарах үйл ажиллагаа зохих үр нөлөөтэй байна.

4.1. Ажил, мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөгөө өгөх, мэдээллээр хангах, ажилд зуучлах арга хэмжээг зохих түвшинд хэрэгжүүлсэн байна.

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2 дахь хэсэгт “Ажил, мэргэжлийн чиг баримжаа олгох, мэргэжлийн зөвлөгөө өгөх, мэдээллээр хангах үйлчилгээг ганцаарчлан болон хэсэг, бүлгээр зохион байгуулна”, 8.3 дахь хэсэгт “Ерөнхий боловсролын сургуулийн ахлах ангийн сурагчид ажил, мэргэжлийн чиг баримжаа олгох үйлчилгээг тухайн сургуулийн захиргаатай хамтран тусгайлсан төлөвлөгөөний дагуу зохион байгуулна” гэж заасны дагуу аймгийн ХХҮГ нь ажил мэргэжлийн чиг баримжаа олгох, мэргэжлийн зөвлөгөө өгөх, мэдээллээр хангах үйлчилгээг зохих хэмжээнд хэрэгжүүлсэн байна.

Аудитад хамрагдсан онуудад ажил, мэргэжлийн чиг баримжаа олгох, мэргэжлийн зөвлөгөө өгөх, мэдээллээр хангах үйлчилгээнд ганцаарчлан болон бүлгээр хамрагдсан иргэдийн тоо, зарцуулсан санхүүжилтийн хэмжээ үр дүнг хүснэгтээр харуулбал дараах байдалтай байна.

Хүснэгт-10

Тайлант он	Зарцуулсан хөрөнгө /мян.төг/	Хамрагдсан нийт иргэний тоо	Бүлгээр хамрагдсан иргэний тоо	Ганцаарчилсан хамрагдсан иргэний тоо	Үр дүн /ажлын байранд зуучлагдсан тоо/
2016	14,540.0	1230	900	330	730
2017	6,808.5	2412	1917	495	630
2018	13,852.6	1757	1103	654	730
2019	15,599.1	2067	1344	723	751
2020	14,194.7	1916	1205	711	681
2021	15,600.0	1931	1223	708	551
Нийт	80,594.9	11313	7692	3621	4073

Эх сурвалж: Аймгийн ХХҮГ-ын статистик мэдээ

Аймгийн ХХҮГ-ын статистик мэдээнээс харахад 2016-2021 онд ажил, мэргэжлийн чиг баримжаа олгох, мэргэжлийн зөвлөгөө өгөх, мэдээллээр хангах үйлчилгээнд 11313 иргэнийг хамруулж, 80,594.9 мянган төгрөгийг зарцуулсны үр дүнд 4073 иргэнийг ажлын байранд зуучилсан байна.

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1 дэх хэсэгт “Аймаг, нийслэл, дүүргийн хөдөлмөр эрхлэлтийн асуудал хариуцсан байгууллага, хөдөлмөрийн бирж нь бүртгэсэн ажил хайгч болон ажилгүйдэлд өртөж болзошгүй иргэнийг ажил олгогчийн эрэлт хэрэгцээг үндэслэн ажилд зуучилна” гэж заасны дагуу аймгийн ХХҮГ нь ажил зуучлах үйлчилгээг зохион байгуулсан байна.

Аудитад хамрагдсан онуудад хүлээн авсан ажлын байрны захиалга, ажилд зуучилсан иргэний тоо, зарцуулсан хөрөнгийг хүснэгтээр харуулбал дараах байдалтай байна.

Хүснэгт-11

Тайлант он	Зарцуулсан хөрөнгө /мян.төг/	Ажлын байрны захиалгын тоо	Ажилд зуучилсан иргэний тоо	Хэрэгжилтийн хувь
2016	2,525.9	1001	999	99.8
2017	4,403.0	1456	1399	96.1
2018	10,878.8	1237	1050	84.9
2019	11,199.9	1394	1200	86.1
2020	8,987.9	1452	1020	70.2
2021	6,160.0	1385	1165	84.1
Нийт	44,155.5	7925	6833	86.2

Эх сурвалж: Аймгийн ХХҮГ-ын статистик мэдээ

Аймгийн ХХҮГ-ын статистик мэдээнээс харахад 2016-2021 онд 7925 ажлын байрны захиалга хүлээн авч 44,155.5 мянган төгрөгийг зарцуулсны үр дүнд 6833 иргэнийг ажлын байранд зуучилсан байна. Ажлын байрны захиалгын тоог ажилд зуучилсан иргэний тоотой харьцуулахад 86.2 хувийн гүйцэтгэлтэй байна.

4.2. Нэгдсэн бүртгэл, мэдээллийн системийн зарим модуль ажиллахгүй, мэдээлэл боловсруулалт удаан байна.

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн 6 дугаар зүйл “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагааны төрөл, хэлбэр”, 6.2.4 дэх заалтад “Нэгдсэн бүртгэл, мэдээллийн үйлчилгээнд хамруулах” гэж заасны дагуу Хөдөлмөрийн зах зээлийн мэдээллийн нэгдсэн систем LMIS программыг 2013 оноос ашиглаж эхэлсэн байна.

Тус программ нийт 7 модультайгаас хөдөлмөр зуучлал, ажил мэргэжлийн чиг баримжаа олгох үйлчилгээ гэсэн 2 төрлийн модуль ашиглагдаж байна.

Хөдөлмөр зуучлал модулиар ажил хайгч, ажилтан, ажил олгогч, ажлын байрны захиалга, ажилгүйдлийн тодорхойлолт зэргийг бүртгэж жагсаалтаар гаргах боломжтой байна. ХХҮГ-ын хариуцсан мэргэжилтэн нь ажил хайгч, ажлын байрны захиалга, зуучлал, шинэ ажлын байрны мэдээг программд шивж, тайланг сар бүр нэгтгэн гаргаж байна.

Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох үйлчилгээ модулиар ганцаарчилсан болон бүлгийн зөвлөгөө мэдээлэл өгөх үйлчилгээг бүртгэж сар бүр тайлагнадаг байна.

Хөдөлмөр зуучлалыг мэдээллийн нэгдсэн системд шивэлт хийх болон тайлан гаргахдаа Үндэсний статистикийн хорооны даргын 2013 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн 1/161 тоот тушаалаар баталсан маягтын дагуу ажил олгогчийг ХЗЗ-1А, ажилтны дэлгэрэнгүй бүртгэлийг ХЗЗ-1А-II, ажил хайгчийг ХЗЗ-2, ажлын байрны захиалгыг ХЗЗ-3 маягтын дагуу тус тус бүртгэж, шинэ ажлын байрны мэдээг А-ХЗЗ-

8А –аас А-ХЗЗ-8В маягтаар, ажил хайгч болон бүртгэлтэй ажилгүй иргэдийг ХЗЗ-6, ХЗЗ-7А, ХЗЗ-7Б маягтаар, ажлын байрны захиалгыг ХЗЗ-8А, ХЗЗ-8Б, ажилд зуучилсан иргэний мэдээг ХЗЗ-9А, ХЗЗ-9Б, ХЗЗ-9В маягтуудаар тус тус тайлагнадаг байна.

Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох зөвлөгөө өгөх үйлчилгээг Хөдөлмөр халамжийн үйлчилгээний ерөнхий газрын даргын 2017 оны 9 дүгээр сарын 25-ны өдрийн А/249 дүгээр тушаалаар баталсан АМЧБО-1, АМЧБО-2 маягтаар бүртгэж, ганцаарчилсан үйлчилгээг ХЗЗҮ-1а, ХЗЗҮ-1б, ХЗЗҮ-1с маягтаар, бүлгийн үйлчилгээг ХЗЗҮ-2а, ХЗЗҮ-2б, ХЗЗҮ-2с маягтаар тус тус тайлагнадаг байна.

Хөдөлмөрийн зах зээлийн мэдээллийн нэгдсэн систем LMIS программаас хөдөлмөр зуучлал модулиар гарсан мэдээллийг нэгтгэн харуулбал дараах байдалтай байна.

Хүснэгт-12

Он	Ажил хайгч иргэний мэдээ	Бүртгэлтэй ажилгүй иргэний мэдээ	Ажлын байрны захиалгын мэдээ	Ажилд зуучилсан иргэдийн мэдээ	Шинэ ажлын байрны мэдээ			Дүн
					Байнгын	Улирал	Түр	
2016	1093	981	1001	999	709			709
2017	1141	777	1456	1399	1300			1300
2018	1077	596	1237	1050	1202			1202
2019	1028	701	1394	1200	755	700	472	1927
2020	1179	831	1452	1020	727	473	373	1573
2021	1178	794	1385	1165	710	400	800	1910
дундаж	1116	780	1321	1139				1437

Эх сурвалж: Аймгийн ХХҮГ-ын статистик мэдээ

Аймгийн ХХҮГ-ын статистик мэдээнээс харахад жилд дунджаар 1116 ажил хайгч иргэнээс 780 иргэн ажил хайгчаар бүртгүүлж, 1321 ажлын байрны захиалгад 1139 иргэнийг зуучилдаг байна. Түүнчлэн шинээр байнгын болон улирлын, түр нийт 1437 ажлын байр бүртгэгдсэн байна.

Хөдөлмөрийн зах зээлийн мэдээллийн нэгдсэн систем LMIS программын мэдээлэл боловсруулалт удаан, зарим модуль ажиллахгүй байгаа тул зайлшгүй шинэчилж сайжруулах шаардлагатай байна. Иймд тус асуудлыг ҮАГ-ын нэгдсэн тайланд тусгуулж холбогдох газруудад зөвлөмж чиглэл хүргүүлэх саналтай байна.

4.3. Хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээнд 2016-2021 онд нийт 124,750.4 мянган төгрөг зарцуулж санхүүгийн тайланд тусгасан байна.

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2 дахь хэсэгт “Хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээг дараах хэлбэрээр хэрэгжүүлнэ” гэж заажээ.

- 6.2.1.ажил, мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөгөө өгөх, мэдээллээр хангах;
- 6.2.2.ажилд зуучлах;
- 6.2.3.ажилгүйдлийн тэтгэмж олгох;
- 6.2.4.нэгдсэн бүртгэл, мэдээллийн үйлчилгээнд хамруулах;
- 6.2.5.бусад үйлчилгээ.

ХХҮГ нь хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээг үзүүлж байна. Аудитад хамрагдсан онуудад ажилгүйдлийн тэтгэмж, бусад үйлчилгээ үзүүлээгүй байна.

Нийтлэг үйлчилгээнд хамрагдсан иргэдийн тоо, зарцуулсан хөрөнгийн хэмжээг хүснэгтээр харуулбал дараах байдалтай байна.

Хүснэгт-13

Тайлант он	Хамрагдсан иргэний тоо	Нийтлэг үйлчилгээнд зарцуулсан хөрөнгө /мянган төгрөг/
2016	2229	17,065.9
2017	3811	11,211.5
2018	2807	24,731.4
2019	3267	26,799.0
2020	2936	23,182.7
2021	3096	21,760.0
Дүн	18146	124,750.5

Эх сурвалж: Аймгийн ХХҮГ-ын статистик мэдээ

Судалгаанаас харахад 2016-2021 онд хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээнд 18146 иргэнийг хамруулж 124,750.5 мянган төгрөгийг зарцуулсан байна. Хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээний дэлгэрэнгүй мэдээллийг тайлангийн 4.1, 4.2 дахь хэсэгт оруулсан болно.

5. Засгийн газраас хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажилгүйдлийг бууруулах, ажлын байр нэмэгдүүлэх чиглэлээр хэрэгжүүлсэн арга хэмжээ үр нөлөөтэй байна.

5.1. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэх, ажилгүйдлийг бууруулах чиглэлээр гадаад болон дотоодын зээл, тусламж, бүх төрлийн сан, олон улсын байгууллагуудын санхүүжилттэй төсөл, хөтөлбөрийн хэрэгжилт тодорхой хэмжээнд үр дүнтэй байна.

Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр батлах тухай” тухайн жилийн тогтоолоор хэрэгжих хөтөлбөр, төсөл, үйлчилгээг батлахдаа хамрагдах хүний тоо, зарцуулах хөрөнгийн хэмжээг тодорхой тусгаж өгсөн байна.

Аудитад хамрагдсан онуудад хэрэгжсэн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр, төсөл, үйлчилгээний хэрэгжилтийг хүснэгтээр харуулбал дараах байдалтай байна.

Хүснэгт-14

№	Хөтөлбөрийн нэр	Төсөл хөтөлбөрийн хэрэгжилтийн хувь						Хамрагдсан иргэдийн тоо	Нэмэгдсэн ажлын байрны тоо	
		2016	2017	2018	2019	2020	2021		Байнгын	Түр
1	Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөх үйлчилгээг дэмжих хөтөлбөр	99						1230	730	
2	Аж ахуй эрхлэх, бичил бизнесийг дэмжих хөтөлбөр	86						502	150	70
3	Хөдөлмөр эрхлэлтийн ур чадвар олгох, ажлын байрыг дэмжих хөтөлбөр	88						452	83	
4	Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр	90					89	192	39	50
5	Хөгжлийн бэрхшээлтэй иргэний ажлын байрыг дэмжих хөтөлбөр	69	60	73	93	93		421	178	1

Төрөөс хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэх чиглэлээр авч хэрэгжүүлсэн бодлогын хэрэгжилт, үр дүн

Увс аймаг дахь Төрийн аудитын газар

6	Малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр	92	100	99	97	99		1624	901	
7	Нийтийг хамарсан ажил зохион байгуулах хөтөлбөр	91						1051		1051
8	Ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээний төсөл	73						58		58
9	Хөдөлмөрт бэлтгэх, хөдөлмөр эрхлэлтийн ур чадвар олгох хөтөлбөр		95	93	57	100		1009		
10	Ажлын байрыг дэмжих хөтөлбөр		93	95	95	86		3307	268	2529
11	Залуучуудын хөдөлмөр эрхлэлт, гарааны бизнесийг дэмжих хөтөлбөр		70	84	85			275	91	50
12	Ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээг хөгжүүлэх хөтөлбөр		66	94	96	98		116	31	85
13	Хөдөлмөрт бэлтгэх хөтөлбөр						66	118		
14	Цар тахлын үед аж ахуй эрхлэгчдийн үйл ажиллагааг сэргээх хөтөлбөр						99	903	105	580
15	Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр						84	183	81	
16	Ахмадын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр						98	48	9	39
17	Залуучуудыг хөдөлмөрт бэлтгэх "Оролцоо" төсөл							118	58	
18	Ажилд зуучлах үйлчилгээ	75	71	100	94	91	100	7859		
19	Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөх үйлчилгээ		86	100	100	95	100	11703		
20	Интерншип туршилтын хөтөлбөр						100	15	15	
ДҮН		84.8	80.1	92.3	89.6	94.8	90.9	31169	2724	4513

Эх сурвалж: Аймгийн ХХҮГ, нэгдсэн судалгаа

Судалгаанаас харахад хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр, төсөл, үйлчилгээний хэрэгжилт дунджаар 80.1-94.8 хувьтай байна. Аудитад хамрагдсан онуудад хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр, төсөл, үйлчилгээнд 31169 хүн хамрагдаж 2724 байнгын, 4513 түр ажлын байр нэмэгдсэн байна.

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр, төсөл, үйлчилгээний батлагдсан төсөв гүйцэтгэлийг хүснэгтээр харуулбал дараах байдалтай байна.

Хүснэгт-15

Он	2015	2016	2017	2018	2019	2020	2021	Дүн
Батлагдсан төсөв /сая.төг/	1162.4	948.3	886.0	941.1	1201.3	862.9	651.7	6653.8
Гүйцэтгэл /сая.төг/	952.7	745.4	761.7	884.4	1012.8	705.9	602.2	5665.0

Эх сурвалж: Аймгийн ХХҮГ, нэгдсэн судалгаа

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр, төсөл, үйлчилгээнд 2015-2021 онд 602.2-1,012.8 сая төгрөг, нийт 5,665.0 сая төгрөг зарцуулсан байна.

ХЭҮЗ-ийн 2021 оны 01 дүгээр тогтоолоор баталсан “Малчдыг малжуулах, санхүүгийн дэмжлэг олгох хөтөлбөр”-ийн 5.2-д “Улаанбаатар хотоос хөдөөд шилжин суурьшиж, мал маллах хүсэлтэй өрхийг дараах байдлаар гэрээт малчнаар ажилд зуучилж, 2 жилийн хугацаанд тогтвортой ажлын байраар хангаж, орлоготой болох арга хэмжээг зохион байгуулна”, 5.2.1-д “Өрхийг гэрээт малчнаар ажилд зуучлах, малжуулах санхүүгийн дэмжлэг олгох...”, ХЭҮЗ-ийн 2022 оны 01 дүгээр тогтоолоор баталсан “Аж ахуй эрхлэгчдийг дэмжих хөтөлбөр”-ийн 4.2.2-д “Өрхийг гэрээт

малчнаар ажиллуулах арга хэмжээ”, 4.2.2.1-д “Улаанбаатар хот, аймгийн төвөөс хөдөөд шилжин суурьшиж, мал маллах хүсэлтэй өрхийг дараах байдлаар гэрээт малчнаар ажилд зуучилж, 2 жилийн хугацаанд тогтвортой ажиллуулах нөхцөлтэй малжуулах санхүүгийн дэмжлэг олгож болно” гэж тус тус заасан байна.

Ингэснээр 2021 онд гэрээт малчныг зөвхөн Улаанбаатар хотоос, 2022 онд Улаанбаатар хот болон аймгийн төвөөс хөдөөд шилжин суурьшсан иргэнээс сонгох шаардлагатай болсон нь тус хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд бэрхшээл тулгарч байна.

Иймд ХЭҮЗ-ийн тогтоолд сумын төвөөс хөдөө багт, сумаас сум хооронд гэрээт малчнаар ажиллах боломжийг тусгаж батлуулах шаардлагатай байна.

Дээрх асуудлыг ҮАГ-ын нэгдсэн тайланд тусгаж холбогдох албан тушаалтанд зөвлөмж, чиглэл хүргүүлэх саналтай байна.

2020 оноос эхлэн эргэн төлөгдөх нөхцөлтэй санхүүгийн дэмжлэг олгохдоо нийгмийн даатгалын шимтгэл төлдөг батлан даагчтай байх шаардлагыг ХХҮЕГ-аас тавьж 2020 оны А/61 дүгээр тушаалаар баталсан гэрээний загварт тусгаж ирүүлснийг аймгийн ХХҮГ хэрэгжүүлэн ажиллаж байна. Ингэснээр гарч болох бүх эрсдэлийг батлан даагч давхар хариуцахаар үүрэг хүлээж санхүүгийн дэмжлэгийн эргэн төлөлт сайжрах нь төрийн байгууллага талдаа үр ашигтай боловч иргэн санхүүгийн дэмжлэгт хамрагдахын тулд гэр бүлийн аль нэг гишүүн нь нийгмийн даатгалын шимтгэл төлдөггүй тохиолдолд гуравдагч этгээдээр батлан даалгахаас өөр аргагүй нөхцөл байдал үүсэж байна. Өөрөөр хэлбэл гэр бүлийн гишүүд хөдөлмөр эрхэлдэггүй тохиолдолд санхүүгийн дэмжлэгт хамрагдахад бэрхшээл үүсэж байгаа нь төслийн үндсэн зорилготойгоо зөрчилдөж байна. Түүнчлэн хууль, тогтоомж, ХЭҮЗ-ийн тогтоолд заагдаагүй “батлан даагч нь заавал нийгмийн даатгалын шимтгэл төлөгч байна” гэсэн нэмэлт шаардлагыг ХХҮЕГ-аас тавьж байгаа асуудлыг нэгдсэн тайланд тусгаж холбогдох албан тушаалтанд зөвлөмж, чиглэл хүргүүлэх саналтай байна.

Аймгийн ХХҮГ нь эргэн төлөгдөх нөхцөлтэй санхүүгийн дэмжлэг олгохдоо ямар нэгэн ажил хийгдээгүй байхад гүйцэтгэлийн тайланг шууд авсан байна. Гүйцэтгэлийн тайланг санхүүгийн дэмжлэг олгохдоо шууд авахгүй тодорхой хугацааны дараа авч байхыг холбогдох албан тушаалтнуудад зөвлөмж болголоо.

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас арилжааны банкаар дамжуулан жилийн 7.2-8.4 хувийн хүүтэй зээл олгосон байна. Уг зээлийн эх үүсвэр нь аймгийн ХХҮГ-аар дамждаггүй, зээл хүссэн иргэдийн ирүүлсэн төсөл нь тавигдах шаардлагад нийцэж байгаа эсэхийг нягталж, арилжааны банканд тодорхойлолт хүргүүлсний үндсэн дээр зээл олгож хэрэгжилтэд хяналт тавьж ажилласан байна.

Аудитад хамрагдсан онуудад олгосон зээлийн хэмжээ, гарсан үр дүнг хүснэгтээр харуулбал дараах байдалтай байна.

Хүснэгт-16

Тайлант он	Төсөл, хөтөлбөр, арга хэмжээ /тоо/	Санхүүжилт /Мян.төг/		Үр дүн
		Дотоод	Гадаад	
2017	1	500,000.0		Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих жижиг зээлд 9 Аж ахуйн нэгж, 42 хувиараа хөдөлмөр эрхлэгч иргэн хамрагдаж 130 байнгын ажлын байр бий болсон байна.

2018	1	800,000.0		Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих жижиг зээлд 133 иргэн хамрагдаж 300 ажлын байр бий болсон байна.
2020	1		517,000.0	Хөдөлмөрийн зах зээлийн туршилтын хөтөлбөрийн бичил бизнес эрхлэгчдийг дэмжих хөтөлбөрт 61 хувиараа хөдөлмөр эрхлэгч иргэн хамрагдаж 106 ажлын байр бий болсон байна.

Эх сурвалж: Аймгийн ХХҮГ

2017-2020 онд гадаад, дотоодын эх үүсвэрээс нийт 1,817,000.0 мянган төгрөгийн зээл олгосны үр дүнд 536 ажлын байр бий болсон байна.

Түүнчлэн аудитад хамрагдсан онуудад Сум хөгжүүлэх сангаас төсөл сонгон шалгаруулалтаар зээл олгож ажлын байрыг нэмэгдүүлсэн байна. Олгосон зээл, шинээр бий болсон ажлын байрны тоог хүснэгтээр харуулбал дараах байдалтай байна.

Хүснэгт-17

Сумын нэр	Нийт /2016-2021 он/			
	Нийт зээл авсан иргэн, ААН-ийн тоо	Олгосон зээл /мян.төг/	Шинээр бий болсон ажлын байр	
			Байнгын	Түр
Баруунтуруун	47	208,000.0	23	16
Бөхмөрөн	15	282,250.0	39	21
Давст	36	237,348.0	19	17
Завхан	18	258,000.0	19	18
Зүүнговь	27	257,100.0	17	0
Зүүнхангай	43	275,000.0	27	16
Малчин	66	230,500.0	44	32
Наранбулаг	31	294,000.0	27	67
Өлгий	34	292,300.0	33	13
Өмнөговь	46	319,900.0	43	6
Өндөрхангай	32	242,982.0	19	16
Сагил	25	174,600.0	17	12
Тариалан	47	503,200.0	34	18
Түргэн	47	224,000.0	47	13
Тэс	35	408,000.0	47	80
Ховд	25	280,000.0	28	24
Хяргас	42	269,000.0	18	36
Цагаанхайрхан	46	313,000.0	37	14
Улаангом	110	850,000.0	125	218
Дүн	772	5,950,179.8	693	637

Эх сурвалж: Аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газар

2016-2021 онд нийт 772 иргэн, ААН-д 5,950,179.8 мянган төгрөгийн зээл олгосны үр дүнд байнгын 693, түр 637 ажлын байр бий болсон байна.

5.2. Төсөл, хөтөлбөрийн хэрэгжилт, санхүүжилт, үр дүнг бодитой тайлагнаж, үнэлсэн байна.

Аймгийн ХХҮГ-ын хяналт, шинжилгээ, үнэлгээ хариуцсан мэргэжилтнүүд төсөл хөтөлбөрийн хэрэгжилт, санхүүжилт, үр дүнг жил бүр үнэлсэн байна. Үнэлгээний үр дүнг дэлгэрэнгүй харуулбал дараах байдалтай байна.

2016 он

Хүснэгт 18

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих чиглэлээр 2016 онд 1 үйлчилгээ, 7 хөтөлбөр, 1 төсөл хэрэгжсэн байна.										2017 онд хийсэн дотоод хяналтын гүйцэтгэлийн хувь	Хүн, хөрөнгө, гүйцэтгэлийн дундаж хувь
Санхүүжилт, орлого /мянган төгрөг/											
1	Хөгжлийн бэрхшээлтэй иргэн ажилуулаагүйн төлбөр	Төлөвлөгөө	8,000.0	Гүйцэтгэл	2,534.4	Зөрүү	5,465.6	Хувь	31.7		
2	Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төв сангийн санхүүжилт	1,006,416.0		798,000.0		208,416.0		79.3			
Орлогын дүн		1,014,416.0	-	800,534.4		213,881.6		78.9			
Төсөл, хөтөлбөрийн зарлага /мянган төгрөг/											
Нэр төрөл	Төлөвлөгөө			Гүйцэтгэл			Хэрэгжилт хувь				
	Хүн	Хөрөнгө		Хүн	Хүн /хувь/	Хөрөнгө				Мөнгөн дүн хувь	
1	Ажилд зуучлах	1000	5,000.0	999	99.9	2,525.9	50.5	75.2			
2	Аж ахуй эрхлэх, бичил бизнесийг дэмжих хөтөлбөр	Санхүүгийн дэмжлэг олгох	70	105,000.0	70	100.0	94,500.0	90.0	95.0	93.3	
		Аж ахуй эрхлэлтийн сургалт явуулах	175	5,250.0	150	85.7	2,400.0	45.7	65.7	65.7	
		Борлуулалтын дэмжлэг	40	12,200.0	40	100.0	12,200.0	100.0	100.0	100.0	
		Түрээсийн хөнгөлөлт	10	12,000.0	11	100.0	3,870.4	32.3	66.1	66.1	
		Хүнсний ногоо тариалах	40	50,000.0	40	100.0	27,736.5	55.5	77.7	77.7	
		Дүн	335	184,450.0	311	92.8	140,706.9	76.3	84.6	90.0	86.4
3	Хөдөлмөр эрхлэлтийн үр чадвар олгох, ажлын байрыг дэмжих хөтөлбөр	Үйлдвэр дээрх сургалт	28	18,200.0	3	10.7	1,638.0	9.0	9.9	9.9	
		Мэргэжлийн сургалт	100	22,000.0	132	100.0	21,020.0	95.5	97.8	97.8	
		Урамшуулал	40	92,160.0	36	90.0	92,829.0	100.0	95.0	86.7	
		Цалингийн дэмжлэг	6	36,000.0	3	50.0	13,704.0	38.1	44.0	63.1	
		Дүн	174	168,360.0	174	100.0	129,191.0	76.7	88.4	88.1	
4	Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр	Гарааны дэмжлэг	16	32,000.0	16	100.0	28,800.0	90.0	95.0	100.0	
		ААЭ сургалт	13	390.0	13	100.0	390.0	100.0	100.0	100.0	
		Борлуулалтын дэмжлэг	14	5,000.0	14	100.0	3,168.0	63.4	81.7	81.7	
		Түрээсийн хөнгөлөлт	8	9,600.0		-		-	-	-	
		Цагийн ажил		3,000.0			3,000.0	100.0	100.0	100.0	
		Дүн	37	49,990.0	43	100.0	35,358.0	70.7	85.4	100.0	90.2
5	Хөгжлийн бэрхшээлтэй иргэний ажлын байрыг дэмжих хөтөлбөр	Хөтчийн дэмжлэг	1	360.0	1	100.0	294.0	81.7	90.8	57.5	
		Санхүүгийн дэмжлэг	60	60,000.0	42	70.0	42,000.0	70.0	70.0	80.0	
		Борлуулалтын дэмжлэг	4	2,000.0	4	100.0	2,000.0	100.0	100.0	100.0	
		Ажлын байрны түрээсийн хөнгөлөлт	5	3,000.0		-		-	-	-	
		Аж ахуй эрхлэлтийн сургалт	100	2,500.0	61	61.0	1,215.0	48.6	54.8	54.8	
		Хөдөлмөр эрхлэлтийн сургалт	15	5,100.0		-		-	-	-	
		Ажил олгогчийн урамшуулал	4	9,216.0	4	100.0	9,216.0	100.0	100.0	100.0	
		Дүн	189	82,176.0	112	59.3	54,725.0	66.6	62.9	80.0	68.6
6	Малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр	Малчдын дэмжлэг	70	315,000.0	70	100.0	285,075.0	90.5	95.3	100.0	
		Шавь сургалт	10	1,400.0		-		-	-	-	
		Туршлага солилцох уулзалт		5,600.0							
		Дүн	80	322,000.0	70	87.5	285,075.0	88.5	88.0	100.0	92.0
7	Нийтийг хамарсан ажил зохион байгуулах хөтөлбөр	Нийтийг хамарсан ажил зохион байгуулах	400	105,600.0	456	100.0	71,749.6	67.9	84.0	84.0	
		Дүн	400	105,600.0	456	114.0	71,749.6	67.9	91.0	91.0	
8	Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөх үйлчилгээг дэмжих хөтөлбөр	ЕБС-ийн сурагчдад ажил, мэргэжлийн чиг баримжаа олгох	330	3,960.0	330	100.0	3,960.0	100.0	100.0	100.0	
		Ажилгүй иргэдэд ажил, мэргэжлийн чиг баримжаа олгох	900	10,800.0	1302	100.0	10,580.0	98.0	99.0	99.0	
		Дүн	1230	14,760.0	1632	100.0	14,540.0	98.5	99.3	99.3	
		Дүн	80	16,000.0	58	72.5	11,600.0	72.5	72.5	72.5	
9	Ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээний төсөл	Зөвлөх мэргэжилтэн ажиллуулах	80	16,000.0	58	72.5	11,600.0	72.5	72.5	72.5	
		Дүн	80	16,000.0	58	72.5	11,600.0	72.5	72.5	72.5	
Нийт дүн		3493	948,336.0	3855	100.0	745,471.4	78.6	89.3	92.5	84.8	
Дүгнэлт											
Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих чиглэлээр хэрэгжүүлж буй төсөл, хөтөлбөрийн зарцуулалт, үйлчилгээнд хамрагдсан иргэн, гүйцэтгэлд хийсэн хяналтын хувийн дунджаар хэрэгжилтийг тооцвол 84.8% байна.											
Тухайн онд санхүүжилт 208.4 сая төгрөгийн санхүүжилт дутуу олгосны улмаас 65.3 сая төгрөгийн өглөг үүссэн байна.											
Хөгжлийн бэрхшээлтэй иргэн ажилуулаагүйн төлбөр 2.5 сая төгрөг ХЭДС-д төвлөрүүлсэн байна.											
Хөдөлмөр эрхлэлтийн хэлтэст зөвлөмж											
Төсөл, хөтөлбөрийн арга хэмжээ бүрийн хэрэгжилтийг хангуулж ажиллах.											
Өглөг үүсгэхгүй байх.											
Санхүүгийн дэмжлэгийн эргэн төлөлтийн эргэн төлөлтийг гэрээнд тусгагдсан хуваарийн дагуу төвлөрүүлэн ажиллах.											

Эх сурвалж: Аймгийн ХХҮГ

2017 он

Хүснэгт 19

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих чиглэлээр 2017 онд 2 үйлчилгээ, 6 хөтөлбөр хэрэгжсэн байна.										2018 онд хийсэн дотоод хяналтын гүйцэтгэлийн хувь	Хүн, хөрөнгө, гүйцэтгэлийн дундаж хувь	
Сангийн орлогын бүрдүүлэлт /мянган төгрөг/												
		Төлөвлөгөө		Гүйцэтгэл		зөрүү		хувь				
1	ХЭД төв сангийн санхүүжилт	Тайлант оны гүйцэтгэлд	886,039.0	749,504.0	136.535.0	85%						
2	ХБИ ажиллуулаагүйн төлбөрийн орлого	Өмнөх оны өр барагдуулахад	58,421.0	58,421.0	136.535.1							
		Орлогын нийт дүн	944,460.0	1	808,645.0	136.535.2						
Төсөл, хөтөлбөрийн зарлага /мянган төгрөг/												
Нэр төрөл		Төлөвлөгөө		Гүйцэтгэл			Хэрэгжилт хувь					
		Хүн	Хөрөнгө	Хүн	Хүн /хувь/	Хөрөнгө		Мөнгөн дүн хувь				
1	Ажил, мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөгөө өгөх үйлчилгээ	1125	9,450.0	2412	100.0	6,808.5	72.0	86.0	86.0			
2	Ажилд зуучлах үйлчилгээ	900	10,304.0	1400	100.0	4,403.0	42.7	71.4	71.0			
3	Хөдөлмөрт бэлтгэх, хөдөлмөр эрхлэлтийн үр чадвар олгох хөтөлбөр	Хөдөлмөрт бэлтгэх арга хэмжээ	105	4,725.0	429	100.0	3,094.0	65.5	82.7	82.7		
		Үйлдвэрлэл дээрх сургалт	21	14,700.0	21	100.0	10,080.0	68.6	84.3	84.3		
		Мэргэжлийн болон давтан сургалт	95	21,850.0	123	100.0	24,133.2	110.4	105.2	105.2		
		Дүн	221	41,275.0	573	100.0	37,307.2	90.4	95.2	95.0		
4	Ажлын байрыг дэмжих хөтөлбөр	Санхүүгийн дэмжлэг /100 хувь эргэн төлөгдөх/	55	165,000.0	74	100.0	165,000.0	100.0	100.0	90.0	96.7	
		Аж ахуй эрхлэлтийн үр чадвар олгох сургалт	154	4,620.0	175	100.0	4,620.0	100.0	100.0	100.0		
		Борлуулалтын дэмжлэг		7,200.0	0		3,117.4	43.3	21.6	21.6		
		Ажлын байрны түрээсийн хөнгөлөлт	16	7,680.0	0	-	-	-	-	-		
		Ажил олгогчид олгох дэмжлэг	8	23,040.0	0	-	2,496.0	10.8	5.4	5.4		
		Нийтийг хамарсан ажил	151	155,980.0	846	100.0	154,736.0	99.2	99.6	99.6		
		Цагийн ажилд зуучлах	0	-	0	-	-	-	-	-		
		Дүн	50	25,000.0	61	100.0	17,645.5	70.6	85.3	85.3		
5	Залуучуудын хөдөлмөр эрхлэлт, гарааны бизнесийг дэмжих хөтөлбөр	Гарааны бизнес эрхлэхийг дэмжих	0	-	0	-	-	-	-	-		
		Санхүүгийн дэмжлэг /100 хувь эргэн төлөгдөх/	25	50,000.0	24	96.0	52,000.0	100.0	98.0	100.0	98.7	
		Борлуулалтын дэмжлэг		7,200.0	0		220.0	3.1	1.5	1.5		
		Ажлын байрны түрээсийн хөнгөлөлт	8	3,840.0	0	-	-	-	-	-		
		Дүн	67	2,010.0	0	-	1,620.0	80.6	40.3	40.3		
6	Малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр	Малчин өрхийг малжуулах /100 хувь эргэн төлөгдөх/	40	200,000.0	90	100.0	200,000.0	100.0	100.0	100.0		
		Мал аж ахуй эрхлэлтийн сургалт, туршлага солилцох уулзалт	72	9,000.0	95	100.0	4,781.0	53.1	76.6	76.6		
		Дүн	112	209,000.0	185	100.0	204,781.0	98.0	99.0	100.0		
7	Хөгжлийн бэрхшээлтэй иргэний ажлын байрыг дэмжих хөтөлбөр	Хөдөлмөрт бэлтгэх арга хэмжээ	25	1,750.0	0	-	-	-	-	-		
		Дэмжлэгтэйгээр ажилд зуучлах үйлчилгээ	12	1,680.0	0	-	1,655.0	98.5	49.3	49.3		
		Санхүүгийн дэмжлэг /100 хувь эргэн төлөгдөх/	20	60,000.0	40	100.0	60,000.0	100.0	100.0	95.0	98.3	
		Борлуулалтын дэмжлэг		7,200.0	0		484.0	6.7	3.4	3.4		
		Ажлын байрны түрээсийн хөнгөлөлт	5	2,400.0	0	-	-	-	-	-		
		Аж ахуй эрхлэлтийн үр чадвар олгох сургалт	100	3,000.0	21	21.0	1,290.0	43.0	32.0	32.0		
		Хөдөлмөр эрхлэлтийн сургалт	17	4,930.0	0	-	-	-	-	-		
		Дүн	2	5,760.0	0	-	-	-	-	-		
8	Ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээг хөгжүүлэх хөтөлбөр	Ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээ	99	27,720.0	7	7.1	24,113.3	87.0	47.0	47.0		
		Санхүүгийн дэмжлэг /100 хувь эргэн төлөгдөх/	8	20,000.0	10	100.0	19,400.0	97.0	98.5	90.0	95.7	
		Дүн	107	47,720.0	17	15.9	43,513.3	91.2	53.5	90.0	66.0	
		Нийт дүн	3190	886,039.0	5828	100.0	761,696.8	86.0	93.0	95.0	80.1	

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих чиглэлээр хэрэгжүүлж буй төсөл, хөтөлбөрийн зарцуулалт, үйлчилгээнд хамрагдсан иргэн, гүйцэтгэлд хийсэн хяналтын хувийн дундажаар хэрэгжилтийг тооцвол 80.1% байна. Тухайн онд санхүүжилт 136.5 сая төгрөгийн санхүүжилт дутуу олгосон байна. Хөгжлийн бэрхшээлтэй иргэн ажиллуулаагүйн төлбөр 720.0 мянган төгрөг ХЭДС-д төвлөрүүлсэн байна. Урьд оны өглөг 58.4 сая төгрөг барагдуулсан байна.

Эх сурвалж: Аймгийн ХХҮГ

2018 он

Хүснэгт 20

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих чиглэлээр 2018 онд 2 үйлчилгээ, 6 хөтөлбөр, 1 туршилтын төсөл хэрэгжсэн байна.										2019 онд хийсэн дотоод хяналтын гүйцэтгэлийн Хувь	Хүн, хөрөнгө, гүйцэтгэлийн дундаж хувь
Сангийн орлогын бүрдүүлэлт /мянган төгрөг/											
1	ХЭД төв сангийн санхүүжилт	Тайлант оны гүйцэтгэлд	Төлөвлөгөө		Гүйцэтгэл		зөрүү	хувь			
			-	1,031,728.2	-		983,500.0	48.2	95%		
Орлогын нийт дүн			-	1,031,728.2	-		983,500.0				
Зарцуулалт /мянган төгрөг/										2019 онд хийсэн дотоод хяналтын гүйцэтгэлийн Хувь	Хүн, хөрөнгө, гүйцэтгэлийн дундаж хувь
Нэр төрөл		Төлөвлөгөө		Гүйцэтгэл			Хэрэгжилт хувь				
		Хүн	Хөрөнгө	Хүн	Хүн /хувь/	Хөрөнгө					
1	Ажил, мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөгөө өгөх үйлчилгээ	1680	13860.0	1680	100.0	13852.6	99.9	100.0		100.0	
2	Ажилд зуучлах үйлчилгээ	840	10880.0	1000	100.0	10878.8	100.0	100.0		100.0	
3	Хөдөлмөрт бэлтгэх, хөдөлмөр эрхлэлтийн ур чадвар олгох хөтөлбөр	Хөдөлмөрт бэлтгэх арга хэмжээ	105	4725.0	105	100.0	4725.0	100.0	100.0		100.0
		Үйлдвэрлэл дээрх сургалт	22	15400.0	22	100.0	10560.0	68.6	84.3		84.3
		Мэргэжлийн болон давтан сургалт	63	14490.0	70	100.0	14460.0	99.8	99.9		99.9
		Дүн	190	34615.0	197	100.0	29745.0	85.9	93.0		93.0
4	Ажлын байрыг дэмжих хөтөлбөр	Санхүүгийн дэмжлэг /100 хувь эргэн төлөгдөх/	61	183000.0	68	100.0	183000.0	100.0	100.0	90.0	96.7
		Аж ахуй эрхлэлтийн ур чадвар олгох сургалт	168	5040.0	168	100.0	5040.0	100.0	100.0		100.0
		Борлуулалтын дэмжлэг	0	7200.0			7200.0	100.0	50.0		50.0
		Ажлын байрны түрээсийн хөнгөлөлт	19	9120.0	2	10.5	960.0	10.5	10.5		10.5
		Ажил олгогчид олгох дэмжлэг	11	31680.0	8	72.7	23040.0	72.7	72.7		72.7
		Нийтийг хамарсан ажил	320	89600.0	578	100.0	88956.0	99.3	99.6		99.6
		Цагийн ажилд зуучлах	210	1470.0	0	0.0	0.0	0.0	0.0		0.0
		Бүлгийн зохион байгуулалттай хүнсний ногоо тариалах	55	27500.0	51	92.7	26643.9	96.9	94.8		94.8
Дүн	844	354610.0	875	100.0	334839.9	94.4	97.2	90.0	94.8		
5	Залуучуудын хөдөлмөр эрхлэлт, гарааны бизнесийг дэмжих хөтөлбөр	Гарааны бизнесийг хөгжүүлэх арга хэмжээг зохион байгуулах	1	10000.0	54	100.0	10000.0	100.0	100.0		100.0
		Гарааны бизнесийн дэмжлэг/100 хувь эргэн төлөгдөх/	4	40000.0	4	100.0	40000.0	100.0	100.0	100.0	100.0
		Санхүүгийн дэмжлэг /100 хувь эргэн төлөгдөх/	12	36000.0	13	100.0	36000.0	100.0	100.0		100.0
		Борлуулалтын дэмжлэг		7200.0	0		7197.2	100.0	50.0		50.0
		Ажлын байрны түрээсийн хөнгөлөлт	11	5280.0	0	0.0	0.0	0.0	0.0		0.0
		Аж ахуй эрхлэлтийн ур чадвар олгох сургалт	84	2520.0	48	57.1	1440.0	57.1	57.1		57.1
Дүн	111	101000.0	65	58.6	94637.2	93.7	76.1	100.0	84.1		
6	Магчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр	Малчин өрхийг малжуулах /100 хувь эргэн төлөгдөх/	60	300000.0	65	100.0	300000.0	100.0	100.0	100.0	100.0
		Мал аж ахуй эрхлэлтийн сургалт, туршлага солилцох уулзалт	120	15000.0	288	100.0	10142.0	67.6	83.8		83.8
		Дүн	180	315000.0	353	100.0	310142.0	98.5	99.2	100.0	99.5
7	Хөгжлийн бэрхшээлтэй иргэний ажлын байрыг дэмжих хөтөлбөр	Хөдөлмөрт бэлтгэх арга хэмжээ	21	1470.0	21	100.0	1470.0	100.0	100.0		100.0
		Дэмжлэгтэйгээр ажилд зуучлах үйлчилгээ	3	1260.0	0	0.0	0.0	0.0	0.0		0.0
		Санхүүгийн дэмжлэг /100 хувь эргэн төлөгдөх/	10	50000.0	26	100.0	50000.0	100.0	100.0	88.0	96.0
		Борлуулалтын дэмжлэг		7200.0	0		7199.5	100.0	50.0		50.0
		Ажлын байрны түрээсийн хөнгөлөлт	4	1920.0	0	0.0	0.0	0.0	0.0		0.0
		Аж ахуй эрхлэлтийн ур чадвар олгох сургалт	74	2220.0	0	0.0	0.0	0.0	0.0		0.0
		Хөдөлмөр эрхлэлтийн сургалт	15	4350.0	21	100.0	4320.0	99.3	99.7		99.7
		Ажил олгогчийн урамшуулал	4	11520.0	0	0.0	0.0	0.0	0.0		0.0
Дүн	131	79940.0	68	51.9	62989.5	78.8	65.4	88.0	72.9		
8	Ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээг хөгжүүлэх хөтөлбөр	Ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээ	29	16240.0	27	93.1	12316.5	75.8	84.5		84.5
		Санхүүгийн дэмжлэг /100 хувь эргэн төлөгдөх/	5	15000.0	5	100.0	15000.0	100.0	100.0	100.0	100.0
		Дүн	34	31240.0	32	94.1	27316.5	87.4	90.8	100.0	93.9
Нийт дүн		4010	941145.0	4270	100.0	884401.5	94.0	97.0	95.6	92.3	
Дүгнэлт											
Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих чиглэлээр хэрэгжүүлж буй төсөл, хөтөлбөрийн зарцуулалт, үйлчилгээнд хамрагдсан иргэн, гүйцэтгэлд хийсэн хяналтын хувийн дунджаар хэрэгжилтийг тооцвол 92.3% байна.											
Хөгжлийн бэрхшээлтэй иргэн ажиллуулаагүйн төлбөр төвлөрүүлээгүй байна.											
Тухайн оны санхүүжилтээс 48.2 сая төгрөг дутуу олгосон байна.											
Өглөг үүсгээгүй байна.											
Хөдөлмөр эрхлэлтийн хэлтэст зөвлөмж											
Төсөл, хөтөлбөрийн арга хэмжээ бүрийн хэрэгжилтийг хангуулж ажиллах.											
Санхүүгийн дэмжлэгийн эргэн төлөлтийн эргэн төлөлтийг гэрээнд тусгагдсан хуваарийн дагуу эргэн төлүүлэх иргэдэд мэдэгдэл өгөх.											

Эх сурвалж: Аймгийн ХХҮГ

2019 он

Хүснэгт 21

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих чиглэлээр 2019 онд 2 үйлчилгээ, 6 хөтөлбөр хэрэгжсэн байна.										2020 онд хийсэн дотоод хяналтын гүйцэтгэлийн хувь	Хүн, хөрөнгө, гүйцэтгэлийн дундаж хувь
Сангийн орлогын бүрдүүлэлт /мянган төгрөг/											
			Төлөвлөгөө			Гүйцэтгэл	зөрүү	хувь			
1	ХЭД төв сангийн санхүүжилт	Тайлант оны гүйцэтгэлд		1,262,920.0	-	1,184,000.0	78,920.0	94%			
2	Санхүүгийн дэмжлэгийн эргэн төлөлт			-	208.0	218,933.5					
Орлогын нийт дүн				1,262,920.0	208.0	1,402,933.5					
Сангийн зарцуулалт /мянган төгрөг/										2020 онд хийсэн дотоод хяналтын гүйцэтгэлийн хувь	Хүн, хөрөнгө, гүйцэтгэлийн дундаж хувь
Нэр төрөл		Төлөвлөгөө		Гүйцэтгэл			Хэрэгжилт хувь				
		Хүн	Хөрөнгө	Хүн	Хүн /хувь/	Хөрөнгө					
1	Ажил, мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөгөө өгөх үйлчилгээ		1900	15,600.0	1900	100.0	15,599.1	100.0	100.0		100.0
2	Ажилд зуучлах үйлчилгээ		1600	11,200.0	1400	87.5	11,199.9	100.0	93.7		93.7
3	Хөдөлмөрт бэлтгэх, хөдөлмөр эрхлэлтийн үр чадвар олгох хөтөлбөр	Хөдөлмөрт бэлтгэх арга хэмжээ	105	4,725.0	105	100.0	4,725.0	100.0	100.0		100.0
		Үйлдвэрлэл дээрх сургалт	22	15,400.0	5	22.7	1,800.0	11.7	17.2		17.2
		Мэргэжлийн болон давтан сургалт	63	14,490.0	69	100.0	14,480.0	99.9	100.0		100.0
		Дүн	190	34,615.0	100	52.6	21,005.0	60.7	56.7		56.7
4	Ажлын байрыг дэмжих хөтөлбөр	Санхүүгийн дэмжлэг /100 хувь эргэн төлөгдөх/	51	255,000.0	55	107.8	255,000.0	100.0	103.9	100.0	100.0
		Аж ахуй эрхлэлтийн үр чадвар олгох сургалт	160	4,800.0	152	95.0	4,560.0	95.0	95.0		95.0
		Борлуулалтын дэмжлэг болон ажлын байрны түрээсийн хөнгөлөлт		14,880.0			12,550.9	84.3	42.2		42.2
		Ажил олгогчид олгох дэмжлэг	3	11,520.0	3	100.0	9,440.0	81.9	91.0		91.0
		Нийтийг хамарсан ажил	340	95,200.0	582	100.0	95,136.2	99.9	100.0		100.0
		Зохион байгуулалттай ажлын байрыг дэмжих арга хэмжээ	32	60,000.0	21	65.6	7,988.0	13.3	39.5		39.5
		Бүлгийн зохион байгуулалттай хүнсний ногоо тариалах	55	27,500.0	60	100.0	15,824.8	57.5	78.8		78.8
		Дүн	641	468,900.0	873	100.0	400,499.9	85.4	92.7	100.0	95.1
5	Залуучуудын хөдөлмөр эрхлэлт, гарааны бизнесийг дэмжих хөтөлбөр	Гарааны бизнесийг хөгжүүлэх арга хэмжээг зохион байгуулах	1	10,000.0	1	100.0	7,500.0	75.0	87.5		87.5
		Гарааны бизнесийн дэмжлэг/100 хувь эргэн төлөгдөх/	18	180,000.0	14	77.8	140,000.0	77.8	77.8	95.0	83.5
		Борлуулалтын дэмжлэг болон ажлын байрны түрээсийн хөнгөлөлт		14,880.0			2,401.8	16.1	8.1		8.1
		Аж ахуй эрхлэлтийн үр чадвар олгох сургалт	92	2,760.0	82	89.1	2,460.0	89.1	89.1		89.1
		Дүн	110	207,640.0	96	87.3	152,361.8	73.4	80.3	95.0	85.2
6	Малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр	Малчин өрхийг малжуулах /100 хувь эргэн төлөгдөх/	56	280,000.0	62	100.0	280,000.0	100.0	100.0	100.0	100.0
		Гэрээт малчин өрхийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих арга хэмжээ	39	39,000.0	15	38.5	4,839.6	12.4	25.4		25.4
		Мал аж ахуй эрхлэлтийн сургалт, туршлага солилцох уулзалт	220	27,500.0	325	100.0	27,476.1	99.9	100.0		100.0
		Дүн	315	346,500.0	402	100.0	312,315.7	90.1	95.1	100.0	96.7
7	Хөгжлийн бэрхшээлтэй иргэний ажлын байрыг дэмжих хөтөлбөр	Хөдөлмөрт бэлтгэх арга хэмжээ	21	1,470.0		-	-	-	-		-
		Дэмжлэгтэйгээр ажилд зуучлах үйлчилгээ	3	1,260.0		-	-	-	-		-
		Санхүүгийн дэмжлэг /100 хувь эргэн төлөгдөх/	11	55,000.0	31	100.0	55,000.0	100.0	100.0	95.0	98.3
		Борлуулалтын дэмжлэг болон ажлын байрны түрээсийн хөнгөлөлт		9,600.0			794.0	8.3	4.1		4.1
		Аж ахуй эрхлэлтийн үр чадвар олгох сургалт	74	2,220.0	74	100.0	2,220.0	100.0	100.0		100.0
		Хөдөлмөр эрхлэлтийн сургалт	15	4,350.0	19	100.0	3,952.0	90.9	95.4		95.4
		Дүн	124	73,900.0	124	100.0	61,966.0	83.9	91.9	95.0	93.0
8	Ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээ	Ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээ	19	15,960.0	35	100.0	15,424.5	96.6	98.3		98.0
		Санхүүгийн дэмжлэг /100 хувь эргэн төлөгдөх/	9	27,000.0	8	88.9	22,500.0	83.3	86.1	100.0	90.7
		Дүн	28	42,960.0	43	100.0	37,924.5	88.3	94.1	100.0	96.1
Нийт дүн			4908	1,201,315.0	4938	100.0	1,012,871.8	84.3	92.2	98.0	89.6
Дүгнэлт											
Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих чиглэлээр хэрэгжүүлж буй төсөл, хөтөлбөрийн зарцуулалт, үйлчилгээнд хамрагдсан иргэн, гүйцэтгэлд хийсэн хяналтын хувийн дундаж хэрэгжилтийг тооцвол 89.6% байна.											
Тухайн онд санхүүжилт 78.9 сая төгрөгийн санхүүжилт дутуу олгосон байна.											
Хөгжлийн бэрхшээлтэй иргэн ажиллуулаагүйн төлбөр төвлөрүүлээгүй байна.											
Өглөг үүсгээгүй байна.											
Хөдөлмөр эрхлэлтийн хэлтэст зөвлөмж											
Төсөл, хөтөлбөрийн арга хэмжээ бүрийн хэрэгжилтийг хангуулж ажиллах.											
Санхүүгийн дэмжлэгийн эргэн төлөлтийн эргэн төлөлтийг гэрээнд тусгагдсан хуваарийн дагуу эргэн төлүүлэх иргэдэд мэдэгдэл өгөх, шүүхэд шилжүүлэх.											

Эх сурвалж: Аймгийн ХХҮГ

2020 он

Хүснэгт 22

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих чиглэлээр 2020 онд 2 үйлчилгээ, 5 хөтөлбөр, 1 төсөл хэрэгжсэн байна.									2021 онд хийсэн дотоод хяналтын гүйцэтгэлийн хувь	Хүн, хөрөнгө, гүйцэтгэлийн дундаж хувь	
Сангийн орлогын бүрдүүлэлт /мянган төгрөг/											
	Төлөвлөгөө			Гүйцэтгэл			зөрүү	хувь			
1	Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төв сангийн санхүүжилт	-	912,379.6	-		753,000.0	159,379.0	83%			
2	Санхүүгийн дэмжлэгийн эргэн төлөлт	-	-	401.0		319,150.0					
Орлогын нийт дүн		-	912,379.6	401.0		1,072,150.0					
Сангийн зарцуулалт /мянган төгрөг/											
Нэр төрөл	Төлөвлөгөө		Гүйцэтгэл				Хэрэгжилт хувь				
	Хүн	Хөрөнгө	Хүн	Хүн /хувь/	Хөрөнгө	Мөнгөн дүн хувь					
1	Ажил, мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөгөө өгөх үйлчилгээ	1900	15600.0	1926	100.0	14194.8	91.0	95.5	95.5		
2	Ажилд зуучлах үйлчилгээ	1000	11000.0	1020	100.0	8988.0	81.7	90.9	90.9		
3	Хөдөлмөрт бэлтгэх, хөдөлмөр эрхлэлтийн ур чадвар олгох хөтөлбөр	Хөдөлмөрт бэлтгэх арга хэмжээ	60	2250.0	60	100.0	2250.0	100.0	100.0		
		Дүн	60	2250.0	60	100.0	2250.0	100.0	100.0		
4	Ажлын байрыг дэмжих хөтөлбөр	Санхүүгийн дэмжлэг /100 хувь эргэн төлөгдөх/	56	278000.0	71	100.0	260000.0	93.5	96.8	100.0	97.8
		Борлуулалтын дэмжлэг болон ажлын байрны түрээсийн хөнгөлөлт		19680.0			6000.0	30.5	15.2		15.2
		Ажил олгогчид олгох дэмжлэг	9	54000.0	2	22.2	7880.0	14.6	18.4		18.4
		Нийтийг хамарсан ажил	344	96600.0	280	81.4	49526.0	51.3	66.3		66.3
		Бүлгийн зохион байгуулалттай хүнсний ногоо тариалах	55	27500.0	50	90.9	20142.9	73.2	82.1		82.1
		Дүн	464	475780.0	403	86.9	343548.9	72.2	79.5	100.0	86.4
5	Малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр	Малчин өрхийг малжуулах /100 хувь эргэн төлөгдөх/	47	234000.0	52	100.0	234000.0	100.0	100.0	100.0	100.0
		Гэрээт малчин өрхийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих арга хэмжээ	2	4000.0		0.0		0.0	0.0		0.0
		Дүн	49	238000.0	52	100.0	234000.0	98.3	99.2	100.0	99.4
6	Хөгжлийн бэрхшээлтэй иргэний ажлын байрыг дэмжих хөтөлбөр	Хөдөлмөрт бэлтгэх арга хэмжээ	21	1470.0	21	100.0	1470.0	100.0	100.0	100.0	100.0
		Санхүүгийн дэмжлэг /100 хувь эргэн төлөгдөх/	17	84000.0	35	100.0	69000.0	82.1	91.1	98.0	93.4
		Дүн	38	85470.0	56	100.0	70470.0	82.4	91.2	98.0	93.5
7	Ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээг хөгжүүлэх хөтөлбөр	Ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээ	11	9800.0	16	100.0	8456.0	86.3	93.1	100.0	95.4
		Санхүүгийн дэмжлэг /100 хувь эргэн төлөгдөх/	8	25000.0	8	100.0	24000.0	96.0	98.0		98.0
		Дүн	19	34800.0	24	100.0	32456.0	93.3	96.6	100.0	97.8
Нийт дүн		3530	862900.0	3541	100.3	705907.6	81.8	91.1	99.5	94.8	
Дүгнэлт											
Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих чиглэлээр хэрэгжүүлж буй төсөл, хөтөлбөрийн зарцуулалт, үйлчилгээнд хамрагдсан иргэн, гүйцэтгэлд хийсэн хяналтын хувийн дунджаар хэрэгжилтийг тооцвол 94.8% байна.											
Тухайн онд санхүүжилт 159.3 сая төгрөгийн санхүүжилт дутуу олгосны улмаас 50.0 сая төгрөгийн өглөг үүссэн байна.											
Хөгжлийн бэрхшээлтэй иргэн ажилуулаагүйн төлбөр төвлөрүүлээгүй байна.											
Хөдөлмөр эрхлэлтийн хэлтэст зөвлөмж											
Төсөл, хөтөлбөрийн арга хэмжээ бүрийн хэрэгжилтийг хангуулж ажиллах.											
Өглөг үүсгэхгүй байх.											
Санхүүгийн дэмжлэгийн эргэн төлөлтийн эргэн төлөлтийг гэрээнд тусгагдсан хуваарийн дагуу эргэн төлүүлэх иргэдэд мэдэгдэл өгөх, шүүхэд шилжүүлэх.											

Эх сурвалж: Аймгийн ХХҮГ

2021 он

Хүснэгт 23

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих чиглэлээр 2021 онд 2 үйлчилгээ, 5 хөтөлбөр, 2 төсөл хэрэгжсэн байна.									
Сангийн орлогын бүрдүүлэлт /мянган төгрөг/									
				Төлөвлөгөө		Гүйцэтгэл		зөрүү	хувь
1	Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих дэд сангуудад санхүүжилт	Тухайн оны санхүүжилт		708,123.5		693,011.7		15,112.0	98%
2	Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих дэд сангуудад санхүүжилт	2020 оны өр барагдуулах		50,053.7		50,053.7			
				708,123.5		743,065.4			
Сангийн зарцуулалт /мянган төгрөг/									
Нэр төрөл			Төлөвлөгөө		Гүйцэтгэл			Хэрэгжилт хувь	
			Хүн	Хөрөнгө	Хүн /хувь/	Хөрөнгө	Мөнгөн дүн хувь		
Төсөл, хөтөлбөрийн зардал									
1	Ажил, мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөгөө өгөх үйлчилгээ		1900	15,600.0	1925	100.0	15,600.0	100.0	100.0
2	Ажилд зуучлах үйлчилгээ		880	6,160.0	1165	100.0	6,160.0	100.0	100.0
1	Хөдөлмөрт бэлтгэх хөтөлбөр	Ажил, мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөгөө, мэдээлэл өгөх	77	576.0	77	100.0	576.0	100.0	100.0
		Ажлын байрны харилцаа, сэтгэл зүйн сургалт зохион байгуулах	77	2,310.0	77	100.0	2,310.0	100.0	100.0
		Ажилд зуучлах уулзалтад бэлтгэх	77	3,850.0		0.0	0.0	0.0	0.0
	Мэргэжлийн болон давтан сургалт зохион байгуулах	Танхимын сургалт зохион байгуулах	39	8,970.0	41	100.0	8,820.0	98.3	99.2
	Хоол унааны зардал	39	8,775.0	18	46.2	1,890.0	21.5	33.8	
Дүн			78	24,481.0	59	75.6	13,596.0	55.5	66.0
2	Цар тахлын үед аж ахуй эрхлэгчдийн үйл ажиллагааг сэргээх хөтөлбөр	Иргэнд санхүүгийн дэмжлэг олгох/эргэн төлөлтэй/	36	180,000.0	60	100.0	180,000.0	100.0	100.0
		Аж ахуй эрхлэлтийн сургалт зохион байгуулах	148	4,440.0	148	100.0	4,440.0	100.0	100.0
	Малчдыг малжуулах	Ажил олгогчид олгох дэмжлэг	4	24,660.0	5	100.0	24,660.0	100.0	100.0
		Малчин өрхийг малжуулах санхүүгийн дэмжлэг олгох	19	95,000.0	20	100.0	93,000.0	97.9	98.9
		Үйл ажиллагааны зардал		11,012.4			8,684.8	78.9	39.4
		Мал маллах арга ухааны сургалт, уулзалт зохион байгуулах	57	6,840.0	70	100.0	6,839.1	100.0	100.0
Борлуулалтын дэмжлэг үзүүлэх арга хэмжээ		13,000.0		0.0	13,000.0	100.0	50.0		
Нийтийг хамарсан ажил зохион байгуулах		300	84,000.0	580	100.0	83,156.3	99.0	99.5	
Дүн			564	418,952.4	883	100.0	413,780.1	98.8	99.0
3	Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр	Засгийн газрын 2020 оны 228 дугаар тогтоолоор батлагдсан Оюутны цагаар хөдөлмөр эрхлэх журмын хэрэгжилтийг хангах, цагийн ажилд зуучлах	50	350.0	50	100.0	350.0	100.0	100.0
		Шилдэг "Старт-Ап" залуучуудад санхүүгийн дэмжлэг олгох	1	10,000.0	1	100.0	10,000.0	100.0	100.0
	Шилдэг "Старт-Ап" залуучуудад санхүүгийн дэмжлэг олгох	"Старт-Ап" залуучуудад ментор хийх	1	8,000.0	66	100.0	4,000.0	50.0	75.0
		Дүн	2	18,350.0	67	100.0	14,350.0	78.2	89.0
4	Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр	Хөдөлмөрт бэлтгэх арга хэмжээг зохион байгуулах	1	10,000.0		0.0		0.0	0.0
		Санхүүгийн дэмжлэг	Хувиараа хөдөлмөр эрхлэгчид санхүүгийн дэмжлэг үзүүлэх /50 хувь эргэн төлөлтэй/	21	84,000.0	27	100.0	84,000.0	100.0
	Хөгжлийн бэрхшээлтэй иргэнд ажлын байр бий болгосон ажил олгогчид дэмжлэг үзүүлэх	Ажлын байрны түрээсийн төлбөрт дэмжлэг үзүүлэх	45	1,800.0	45	100.0	1,800.0	100.0	100.0
		Урамшуулал олгох		15,120.0				0.0	0.0
		Ажлын байрны түрээсийн төлбөрт дэмжлэг үзүүлэх		14,700.0				0.0	0.0
		Мэргэжлийн болон давтан сургалт зохион байгуулах	Танхимын сургалт зохион байгуулах	7	2,100.0	7	100.0	1,638.0	78.0
Дүн	74	127,720.0	79	100.0	87,438.0	68.5	84.0		
5	Ахмадын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр	Ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээ зохион байгуулах	16	13,440.0	39	100.0	11,970.0	89.1	94.5
		Эргэн төлөгдөх санхүүгийн дэмжлэг олгох	9	27,000.0	9	100.0	27,000.0	100.0	100.0
	Дүн	25	40,440.0	48	100.0	38,970.0	96.4	98.0	
Нийт дүн			743	651,703.4	1136	100.0	589,894.1	90.5	90.9
Дүгнэлт									
Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих чиглэлээр хэрэгжүүлж буй төсөл, хөтөлбөрийн зарцуулалт, үйлчилгээнд хамрагдсан иргэнээр харьцуулан тооцвол 91% байна. Тухайн онд санхүүжилт 15.1 сая төгрөгийн санхүүжилт дутуу олгосон байна. Хөгжлийн бэрхшээлтэй иргэн ажиллуулаагүйн төлбөр төвлөрүүлээгүй байна. Өглөг үүсгээгүй байна.									
Хөдөлмөр эрхлэлтийн хэлтэст зөвлөмж									
Төсөл, хөтөлбөрийн арга хэмжээ бүрийн хэрэгжилтийг хангуулж ажиллах. Санхүүгийн дэмжлэгийн эргэн төлөлтийн эргэн төлөлтийг гэрээнд тусгагдсан хуваарийн дагуу эргэн төлүүлэх иргэдэд мэдэгдэл өгөх, шүүхэд шилжүүлэх.									

Эх сурвалж: Аймгийн ХХҮГ

ХХҮГ-ын хяналт, шинжилгээ, үнэлгээ хариуцсан мэргэжилтнүүд төсөл хөтөлбөрийн хэрэгжилт, санхүүжилт, үр дүнг жил бүр үнэлж дүгнэлт, зөвлөмж өгч хэрэгжилтийг тооцож ажилласан байна.

Түүнчлэн төсөл, хөтөлбөрт хамрагдсан иргэдийн зээлийн эргэн төлөлтөд хяналт, үнэлгээ хийж хугацаа хэтэрсэн зээлийг барагдуулах талаар тодорхой арга хэмжээ авч ажилласан байна.

Хүснэгт 24 /мян.төг/

№	Олго сон он	Эргэн төлөх дүн	Тухайн онд төлбөл зохих дүн	Эргэн төлсөн дүн 2015-2020 он	Эргэн төлөлтийн хувь	Хугацаа хэтэрсэн дүн	Хяналтаар шийдвэрлэсэн байдал	
							Авсан арга хэмжээ	Эргэн төлөлт
1	2014	75,000.0	75,000.0	67,500.0	90.0	7,500.0	ШШГГ шилжүүлсэн	2,500.0
2	2015	248,000.0	248,000.0	196,351.1	79.2	51,648.9	ШШГГ шилжүүлсэн	23,591.5
3	2016	157,500.0	157,500.0	142,557.5	90.5	14,942.5	шүүхэд шилжүүлсэн	4,170.5
4	2017	496,400.0	496,400.0	249,150.0	50.2	247,250.0	шүүхэд шилжүүлсэн	109,650.0
5	2018	624,000.0	416,000.0	197,341.0	47.4	218,659.0	мэдэгдэл өгсөн	177,864.9
6	2019	752,500.0	396,125.0	91,843.0	23.2	304,282.0	мэдэгдэл өгсөн	134,425.0
7	2020	552,500.0	-	4,060.0				
Дүн		2,905,900.0	1,789,025.0	948,802.6	53.0	844,282.4		452,201.9

Эх сурвалж: Аймгийн ХХҮГ

2014-2020 онд Санхүүгийн дэмжлэгт хамрагдсан иргэдийн эргэн төлөлтөд хяналт хийж эргэн төлөлтийн хугацаа хэтэрсэн 147 иргэний 257,037.1 мянган төгрөгийн материалыг шүүхэд, 330 иргэнд мэдэгдэл өгснөөр 2021 оны жил эцсийн байдлаар 452,201.9 мянган төгрөг дэмжих санд төвлөрүүлсэн байна.

5.3. Эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих талаар зохих үр дүнтэй арга хэмжээ аваагүй байна.

Төрөөс хөдөлмөр эрхлэлтийн талаар баримтлах бодлогын 4.1.6-д “Хөгжлийн бэрхшээлтэй иргэд, эмэгтэйчүүдийн хөдөлмөрийн зах зээл дэх тэгш оролцоог хангах, зохистой хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх чиглэлээр төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх” гэж заасан байхад 2016-2021 онд эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр, арга хэмжээ хэрэгжээгүй байна. Харин 2022 онд “Эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр”-ийг ХЭҮЗ-ийн 1 дүгээр тогтоолын 7 дугаар хавсралтаар баталсан байна.

Хувиараа хөдөлмөр эрхлэх хүсэлтэй эмэгтэйчүүд их байгааг харгалзан цаашид санхүүгийн дэмжлэгт зарцуулах хөрөнгийн хэмжээг өсгөж хамрагдалтыг нэмэгдүүлэх зайлшгүй шаардлагатай байна.

6. Хөгжлийн бэрхшээлтэй иргэн ажиллуулаагүй ААН, байгууллагын төлбөрийг 2018-2021 онуудад төвлөрүүлээгүй, ХЭДС-ийн хөрөнгийг үр дүнтэй зарцуулсан байна.

6.1. ХЭДС-ийн орлогыг хуульд заасны дагуу бүрэн төвлөрүүлээгүй байна.

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1 дэх хэсэгт Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан дараах эх үүсвэрүүдээс бүрдэхээр заажээ.

- улсын төсвөөс хуваарилсан хөрөнгө;
- орон нутгийн төсвөөс хуваарилсан хөрөнгө;
- Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн чөлөөт үлдэгдлийг банканд хадгалуулсны хүү;
- гадаадын иргэнийг гэрээгээр ажиллуулсан ажил олгогчийн төлөх ажлын байрны төлбөр;
- гадаад улс, олон улсын байгууллагаас хөдөлмөр эрхлэлтийг дэмжих зорилгоор олгосон зээл;
- гадаад улс, олон улсын байгууллага, Монгол Улсын болон гадаад улсын аж ахуйн нэгж, байгууллага, төрийн бус байгууллага, иргэдээс Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих санд оруулсан хандив, тусламж;
- хөгжлийн бэрхшээлтэй хүнийг ажиллуулаагүй аж ахуйн нэгж, байгууллагаас төлөх төлбөр;
- жижиг зээл, санхүүгийн дэмжлэгийн эргэн төлөгдсөн хөрөнгө;
- бусад эх үүсвэр.

Орон нутгийн түвшинд дараах эх үүсвэрээс хөрөнгө төвлөрүүлж байна. Үүнд:

Хүснэгт 25

он	Ирсэн санхүүжилт	Эргэн төлөлтийн орлого	Хөгжлийн бэрхшээлтэй иргэн ажиллуулаагүйн төлбөр	Гадаадын зээл тусламж	Нийт дүн /мян.төг/
2016	798,100.0	51,783.3	2,534.4	-	852,417.7
2017	864,925.0	146,103.5	720.0	-	1,011,748.5
2018	983,500.0	182,133.8	-	-	1,165,633.8
2019	1,184,000.0	218,933.5	-	-	1,402,933.5
2020	753,000.0	319,150.0	-	21,089.5	1,093,239.5
2021	743,065.3	549,770.5	-	30,007.8	1,322,843.6

Эх сурвалж: Аймгийн ХХҮГ

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих дэд сан нь төв сангаасаа санхүүждэг байна. Эргэн төлөлттэй санхүүгийн дэмжлэгийн эргэн төлөлт болон хөгжлийн бэрхшээлтэй иргэн ажиллуулаагүй ААН байгууллагын төлбөрийг Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих санд төвлөрүүлдэг байна.

Харин Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1.7 дахь зүйлд заасан “Хөгжлийн бэрхшээлтэй хүнийг ажиллуулаагүй аж ахуйн нэгж, байгууллагаас төлөх төлбөр”-ийг 2018-2020 онд төвлөрүүлээгүй байна.

Хөдөлмөрийн тухай хуулийн 144 дүгээр зүйлийн 144.2 дахь хэсэгт “Өмчийн төрөл, хэлбэрээс үл хамаарч 25 ба түүнээс дээш ажилтантай аж ахуйн нэгж, байгууллага нийт ажлын байрныхаа дөрвөн хувиас доошгүй орон тоонд хөгжлийн бэрхшээлтэй хүнийг ажиллуулна”, 144.3 дахь хэсэгт “Аж ахуйн нэгж, байгууллага

энэ хуулийн 144.2-т зааснаар хөгжлийн бэрхшээлтэй хүн ажиллуулаагүй бол ажиллуулбал зохих орон тоо тутамд ногдох төлбөрийн хэмжээ нь хөдөлмөрийн хөлсний доод хэмжээтэй тэнцүү байх бөгөөд уг төлбөрийг сар бүр Хөгжлийн бэрхшээлтэй иргэний хөдөлмөр эрхлэлтийг дэмжих дэд санд төлнө” гэж заасны дагуу хөгжлийн бэрхшээлтэй хүнийг ажиллуулаагүй аж ахуйн нэгж, байгууллагаас төлөх төлбөрийг төвлөрүүлэхийг холбогдох албан тушаалтнуудад зөвлөмж болголоо.

6.2. ХЭДС-ийн хөрөнгийг хууль, журмын дагуу зарцуулсан байна.

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.1 дэх хэсэгт хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн хөрөнгийг хөдөлмөр эрхлэлтийг дэмжих 14 төрлийн үйл ажиллагаанд зарцуулахаар зохицуулсан байна. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн батлагдсан төсөв, ирсэн санхүүжилт, зарцуулалтыг хүснэгтээр харуулбал дараах байдалтай байна.

Хүснэгт 26

Он	Батлагдсан төсөв /мян.төг/	Ирсэн санхүүжилт /мян.төг/	Зарцуулалт /мян.төг/	Төвлөрүүлсэн дүн /мян.төг/
2016	1,006,416.0	798,100.0	795,333.6	2,766.4
2017	1,001,460.0	870,209.0	864,954.1	5,254.9
2018	1,031,728.2	983,500.0	952,770.5	30,729.5
2019	1,259,920.0	1,184,000.0	1,071,281.6	112,718.5
2020	933,469.1	774,089.5	749,007.5	25,082.0
2021	775,887.3	773,073.2	723,734.8	49,338.4

Эх сурвалж: Аймгийн ХХҮГ

Увс аймгийн хөдөлмөр эрхлэлтийн сангаас 2016-2021 онд 723,734.8-1,071,281.6 мянган төгрөгийг зарцуулж үлдэгдэл 2,766.4-112,718.5 мянган төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Увс аймаг дахь Төрийн аудитын газраас Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2016 оны санхүүгийн тайланд итгэл үзүүлсэн ба 2017-2021 онуудад “Зөрчилгүй” санал дүгнэлт өгсөн байна.

Эргэн төлөх нөхцөлтэй хөтөлбөртэй холбоотой үүссэн авлагыг хүснэгтээр харуулбал дараах байдалтай байна.

Хүснэгт 27

Жилийн эцсийн үлдэгдэл /мян.төг/					
2016 он	2017 он	2018 он	2019 он	2020 он	2021 он
421,972.2	772,268.7	1,190,177.9	1,723,744.4	1,957,094.4	1,728,323.9

Эх сурвалж: Аймгийн ХХҮГ

Авлагын үлдэгдэл 2021 оноос бусад онуудад жил дараалан өссөн үзүүлэлттэй байна. Үүссэн авлагыг барагдуулах чиглэлээр тодорхой арга хэмжээ авч ажиллахыг холбогдох албан тушаалтнуудад зөвлөмж болголоо.

Авлага өсөхөд эргэн төлөх нөхцөлтэй санхүүгийн дэмжлэгийн хугацаа хэтрэлт шууд нөлөө үзүүлж байна. Иймд эргэн төлөх нөхцөлтэй санхүүгийн дэмжлэгт хамрагдаж байгаа иргэдийн мэдээллийг Монгол банкны зээлийн мэдээллийн санд оруулах асуудлыг нэгдсэн тайланд тусгуулж холбогдох газруудад зөвлөмж чиглэл хүргүүлэх саналтай байна.

ХЭДС-ийн 2016-2021 оны санхүүгийн анхан шатны баримтыг түүврээр шалгахад дараах зөрчил илэрлээ. Үүнд:

- ХЭҮЗ-ийн 2017 оны 1 дүгээр тогтоолоор баталсан "Малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих" хөтөлбөрийн 2.2.1-д "Малчин өрхийг малжуулах арга хэмжээнд хөдөлмөрийн чадвартай, 15-39 насны 2-оос доошгүй гишүүнтэй, бог малд шилжүүлснээр 200 хүртэл толгой малтай малчин өрхийг хамруулна" гэж заасныг зөрчин Зүүнхангай сумын иргэн 47 настай Дандгай овогтой Баттулгыг малжуулсан.
- ХЭҮЗ-ийн 2017 оны 1 дүгээр тогтоолоор баталсан "Малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих" хөтөлбөрийн 2.2.2-д "Арга хэмжээнд хамрагдах малчин өрх нь 150 хүртэл толгой малтай бол 5.0 сая төгрөг, 150-200 толгой малтай бол 4.0 сая төгрөгийн мал худалдан авах арга хэмжээг аймаг, дүүргийн ХХҮГ, хэлтэс зохион байгуулна " гэж заасныг зөрчиж Өлгий сумын иргэн Батсүх овогтой Нямдоржийг /203 толгой малтай/ малжуулах хөтөлбөрт хамруулсан, Өлгий сумын иргэн Балжинням овогтой Дашцэрэнг /179 толгой малтай/ 5.0 сая төгрөгөөр малжуулсан, Баруунтуруун сумын иргэн Нацагдорж овогтой Болдбаатарыг /82 толгой малтай/ 4.0 сая төгрөгөөр малжуулсан.
- ХЭҮЗ-ийн 2017 оны 1 дүгээр тогтоолоор баталсан "Залуучуудын хөдөлмөр эрхлэлт, гарааны бизнесийг дэмжих" хөтөлбөрийн 5.1 -д "Мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагыг төгсөгч-ийг хувиараа болон бүлгээр хөдөлмөр эрхэлж, ажлын байр бий болгох зорилгоор тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл худалдан авахад нь зориулж, нэг төгсөгчид 3 сая төгрөг, бүлэгт 10 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэгийг олгоно. Төгсөгчид бүлэг болсон тохиолдолд 5-аас ихгүй гишүүнтэй байна" гэж заасныг зөрчин н.Оюунгэрэл, н.Ариунчимэг нарын 3 сая төгрөгийн төсөлд тус бүр 1.5 сая төгрөгийн санхүүжилт олгосон, 25 настай О.Аюурзана, Ц.Баянбат нарт тус бүр 2.0 сая төгрөгийн эргэн төлөгдөх санхүүгийн дэмжлэг үзүүлсэн байна.

Цаашид ХЭҮЗ-ийн тогтоолоор баталсан хөтөлбөрт хамрагдахад тавигдах шаардлагыг мөрдөж ажиллахыг холбогдох албан тушаалтнуудад зөвлөмж болголоо.

7. Мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагаас хөдөлмөрт бэлтгэх үйл ажиллагаа үр нөлөөтэй хэрэгжсэн байна.

7.1. МБСДС-аас 2016-2021 онуудад санхүүжилт аваагүй байна.

Улаангом политехник коллежид 2016-2021 онуудад Мэргэжлийн боловсрол, сургалтыг дэмжих сангаас санхүүжилт олгоогүй, хөрөнгө оруулалт хийгдээгүй байна.

7.2. Мэргэжлийн боловсролын байгууллагын санхүүжилт үр нөлөөтэй байна.

Улсын төсвөөс 2016-2021 онуудад Улаангом политехник коллежид олгосон санхүүжилтийг хүснэгтээр харуулбал дараах байдалтай байна.

Хүснэгт 28

Огноо	Батлагдсан төсөв /мян.төг/	Гүйцэтгэл /мян.төг/	Төвлөрүүлсэн /мян.төг/
2016	1,873,541.6	1,847,685.1	25,856.50
2017	1,831,197.1	1,829,182.5	2,014.60
2018	1,770,614.8	1,767,461.1	3,153.70
2019	2,199,110.1	2,167,919.4	31,190.70
2020	2,809,684.9	2,760,008.8	49,676.10
2021	2,920,643.6	2,897,262.3	23,381.30

Эх сурвалж: Улаангом политехник коллеж

Улаангом политехник коллежийн санхүүжилт жил бүр өссөн байна.

Улаангом политехник коллежид 2016-2021 онуудад нэмэлт санхүүжилтээр олгосон төсвийг хүснэгтээр харуулбал дараах байдалтай байна.

Хүснэгт 29

Он	Санхүүжилт өгсөн байгууллагын нэр	Мөнгөн дүн /мян.төг/	Тайлбар
2016	ГОУХАН	11,760.0	ГОУХАН-ийн төслийн ажилтны цалин, утасны төлбөр, хурлын цайны зардал, 2 суралцагчийн тэтгэлэг
	НҮБ-ын эрүүл мэндийн сан	1,350.0	Амьдрах ухааны төвийн зардал
Дүн		13,110.0	
2017	ГОУХАН	10,060.0	ГОУХАН-ийн төслийн ажилтны цалин, утасны төлбөр, хурлын цайны зардал
	ШХА “Тогтвортой бичил уурхай төсөл”	16,741.0	Бичил уурхайчдыг мэргэжлийн болон ХАБЭА-н чиглэлийн сургалт хамруулах. 10 хүнийг мэргэжлийн сургалтад, оёмол бүтээгдэхүүний оёдолчин 12 хүн сурч чадамжийн гэрчилгээ авсан, 184 хүнд сургалт явуулсан
	ХЭДС	12,734.0	Түр сургалтад 44 иргэн хамрагдсан
	Ув.ЭМНДХ	10,000.0	Жижиг, дунд үйлдвэрт ажиллагчид, хувиараа эрхлэгчдийн үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс урьдчилан сэргийлэх, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сургалтад 324 хүн хамрагдсан.
Дүн		49,535.0	
2018	ГОУХАН	8,360.0	ГОУХАН-н төслийн ажилтны цалин, утасны төлбөр, хурлын цайны зардал
	ШХА “Тогтвортой бичил уурхай төсөл”	29,230.0	Бичил уурхайчдыг мэргэжлийн болон ХАБЭА-н сургалтын зардал /Оёмол бүтээгдэхүүний оёдолчин, захиалгын гуталчин, талх нарийн боов үйлдвэрлэгч, мужаан, тогоочийн богино хугацааны сургалт 30 хүний сургалтад хамруулсан/
	ХЭДС	4,560.0	Түр сургалтад 19 хүн хамрагдсан
	Ув.ЭМНДХ	8,000.0	Жижиг, дунд үйлдвэрт ажиллагчид, хувиараа эрхлэгчдийн үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс урьдчилан сэргийлэх, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сургалтын зардал 348 хүн хамруулсан
Дүн		50,150.0	
2019	ГОУХАН	1,070.0	ГОУХАН-н төслийн ажилтны цалин, утасны төлбөр, хурлын цайны зардал
	Завхан, Говь-Алтай, Завхан аймгуудын оролцооны зардал	1,290.0	Баруун бүсийн загварын уралдааны зардал
	Увс ЭМНДХ	2,500.0	Жижиг, дунд үйлдвэрт ажиллагчид, хувиараа эрхлэгчдийн үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс урьдчилан сэргийлэх, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сургалтын зардал 100 хүртэл хүн хамруулсан
Дүн		4,860.0	
2020	Увс. Онцгой байдлын хэлтэс	18,219.5	Тусгаарлалтын байранд байсан хүмүүсийн хоол, тусгаарлалтад ажилласан ажилтны томилолтын зардал

Дүн		18,219.5	
2021	Ув.ОНХС	35,000.0	Шинэ хөдөө төсөл ХАА-н үйлдвэрлэл эрхлэгчдийн сургалт, зөвлөгөөн з/б, технологид суурилсан шинэ ажил
	Хөдөлмөрийн аюулгүй байдал ЭМТ	4,000.0	Эрүүл, аюулгүй ажлын байр эрхэмлэгч байгууллагын шагнал
	Ув.Онцгой байдлын газар	525.0	Тусгаарлах байрны хоолны төлбөр
	Сангийн Яам	135,600.0	Сангийн сайдын тушаалын дагуу машин, тоног төхөөрөмж худалдан авах зардал
Дүн		175,125.0	

Эх сурвалж: Улаангом политехник коллеж

Улаангом политехник коллеж 2016-2021 онуудад нэмэлт санхүүжилтээр 175,125.0 мянган төгрөгийн санхүүжилт авч шаардлагатай арга хэмжээнд зарцуулсан байна.

Улаангом политехник коллежид 2016-2021 онуудын төгсөгчдийн тоо, ажлын байртай болсон төгсөгчдийн судалгааг хүснэгтээр харуулбал дараах байдалтай байна.

Хүснэгт 30

Хичээлийн жил	Төгсөгчдийн тоо	Ажлын байртай болсон төгсөгчдийн тоо	Эзлэх хувь
2016-2017	538	291	54.1
2017-2018	502	302	60.2
2018-2019	423	247	58.4
2019-2020	366	204	55.7
2020-2021	469	249	53.1

Эх сурвалж: Улаангом политехник коллеж

Улаангом политехник коллеж төгсөгчдийн 53.1-60.2 хувь нь төгсөөд 6 сар хүртэл хугацааны дараа ажлын байртай болсон байна.

8. "Ковид-19" цар тахлын үед хөдөлмөр эрхлэлтийн талаар төрөөс авч хэрэгжүүлсэн арга хэмжээ

8.1. Цар тахлын үед аж ахуй эрхлэгчдийн үйл ажиллагааг сэргээх хөтөлбөр хэрэгжүүлсэн байна.

ХЭҮЗ-ийн 2021 оны 02 дугаар сарын 09-ний өдрийн 01 дүгээр тогтоолоор Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих 2021-2022 оны хөтөлбөрүүдийг баталсан байна. Тус тогтоолд Цар тахлын үед аж ахуй эрхлэгчдийн үйл ажиллагааг сэргээх хөтөлбөрийг хэрэгжүүлэхээр тусгагдсан ба төлөвлөгөө, гүйцэтгэлийг хүснэгтээр харуулбал дараах байдалтай байна.

Хүснэгт 31

Нэр төрөл		Төлөвлөгөө		Гүйцэтгэл	
		Хүн	Хөрөнгө /мян.төг/	Хүн	Хөрөнгө /мян.төг/
Төсөл, хөтөлбөрийн зардал					
Цар тахлын үед аж ахуй эрхлэгчдийн үйл ажиллагааг сэргээх хөтөлбөр	Иргэнд санхүүгийн дэмжлэг олгох/эргэн төлөлттэй/	36	180,000.0	60	180,000.0
	Аж ахуй эрхлэлтийн сургалт зохион байгуулах	148	4,440.0	148	4,440.0

	Ажил олгогчид олгох дэмжлэг	4	24,660.0	5	24,660.0
--	-----------------------------	---	----------	---	----------

Эх сурвалж: ХХҮГ

Дээрх хөтөлбөрийг хэрэгжүүлснээр цар тахлын үед хорио цээрийн дэглэмийн улмаас үйл ажиллагаа нь доголдсон аж ахуйн нэгж болон хувиараа хөдөлмөр эрхлэгчдэд зохих дэмжлэг болсон байна.

8.2. Цар тахлын үед ажилтныг дэмжих чиглэлээр авч хэрэгжүүлсэн арга хэмжээ үр дүнтэй байна.

Улсын Их Хурал 2020 онд “Коронавируст халдвар /covid-19/-ын цар тахлын үед иргэдийн эрүүл мэнд, орлогыг хамгаалах, ажлын байрыг хадгалах, эдийн засгийг идэвхжүүлэх багц арга хэмжээний тухай” 21 дүгээр тогтоол гаргаж хэрэгжүүлэн ажилласан байна.

Тогтоолын 2.1-д “Монгол Улсын иргэний 2020 оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөс 2020 оны 10 дугаар сарын 01-ний өдрийг хүртэлх хугацаанд олсон цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлогод ногдох хувь хүний орлогын албан татварыг чөлөөлнө” гэж заасны дагуу тогтоолд хамаарах 1288 иргэний 424,977.4 мянган төгрөгийн хувь хүний орлогын албан татварыг чөлөөлсөн байна.

Тогтоолын 3.2-д “Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 18.2, 18.3, 18.4, 18.5-д заасан албан татвар ногдох орлогын нийт дүн нь өмнөх татварын жилд 1.5 тэрбум төгрөгөөс бага байсан төрийн болон орон нутгийн өмчит, түүний оролцоотой хуулийн этгээдээс бусад Монгол Улсын хуулийн дагуу үүсгэн байгуулагдсан албан татвар төлөгчийн 2020 оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөс 2020 оны 10 дугаар сарын 01-ний өдрийг хүртэлх хугацаанд олсон орлогод мөн хуулийн 20.1, 20.2.7-д заасны дагуу ногдуулан тайлагнасан аж ахуйн нэгжийн орлогын албан татварыг чөлөөлөх” гэж заасны дагуу 356 аж ахуйн нэгжийн 305,434.5 мянган төгрөгийн аж ахуйн нэгжийн орлогын албан татварыг чөлөөлсөн байна.

Тогтоолын 3.4-д “2020 оны 02 дугаар сарын 01-ний өдрөөс 2020 оны 09 дүгээр сарын 01-ний өдрийг хүртэлх хугацаанд татвар төлөгчийн хуулийн дагуу ногдуулан тайлагнасан төлбөл зохих татварыг хуульд заасан хугацаанд төлөөгүй тохиолдолд уг хугацаанд ногдуулах татварын алданги, торгуулиас тухайн татвар төлөгчийг нэг удаа чөлөөлөх” гэж зааснаар татварын алданги, торгуулиас чөлөөлсөн хуулийн этгээд байхгүй байна.

Тогтоолын 2.2-д Коронавируст халдвар /COVID-19/-ын цар тахлын улмаас өөрөөс үл хамаарах шалтгаанаар, төрийн эрх бүхий байгууллагын шийдвэрээр үйл ажиллагаа нь зогссон болон 2020 оны 2, 3 дугаар сарын үйл ажиллагааны борлуулалтын орлого нь өмнөх оны мөн үеэс 50 ба түүнээс дээш хувиар буурсан боловч ажлын байрыг хадгалж байгаа төрийн болон орон нутгийн өмчит, түүний оролцоотой хуулийн этгээдээс бусад аж ахуйн нэгжийн даатгуулагч Монгол Улсын иргэнд 2020 оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөс 2020 оны 07 дугаар сарын 01-ний өдөр хүртэлх хугацаанд ажилгүйдлийн даатгалын сангаас сар бүр 200.0 /хоёр зуун/ мянган төгрөгийн дэмжлэг олгох;

2.3-д “Нийгмийн даатгалын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 3 дахь хэсэгт заасан сайн дураар даатгуулсан, нийгмийн даатгалын байгууллагатай мөн хуулийн 5 дугаар зүйлд заасан сайн дураар даатгуулахаар гэрээ байгуулсан Монгол Улсын иргэний 2020 оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөс 2020 оны 10 дугаар сарын 01-ний өдөр хүртэлх хугацаанд түүний хөдөлмөрийн хөлсний доод хэмжээтэй тэнцүү орлогод ногдох тэтгэвэр, тэтгэмж, үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын шимтгэлийг чөлөөлж, даатгуулагчийг мөн хугацаанд шимтгэл төлснөөр тооцох”;

3.1-д Коронавируст халдвар /COVID-19/-ын цар тахлын улмаас үйл ажиллагаа нь доголдож, орлого нь буурч байгаа боловч ажлын байрыг хадгалж, хуульд заасан хугацаанд нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн тайлан ирүүлсэн дараах хуулийн этгээдэд ажиллаж байгаа даатгуулагчаас бусад даатгуулагчийн хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогод ногдуулсан ажил олгогч болон даатгуулагч /Монгол Улсын иргэн/-ийн 2020 оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөс 2020 оны 10 дугаар сарын 01-ний өдөр хүртэлх хугацаанд төлөх тэтгэвэр, тэтгэмж, ажилгүйдэл болон үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын шимтгэлийг чөлөөлөх ба даатгуулагчийг мөн хугацаанд шимтгэл төлснөөр тооцно” гэж тус тус заасны дагуу хамрагдсан ажил олгогч, даатгуулагчийн тоо, хөнгөлөлт чөлөөлөлт, дэмжлэгийг хүснэгтээр харуулбал дараах байдалтай байна.

Хүснэгт 32

Төрөл	Он	Ажил олгогчийн тоо	Даатгуулагчийн тоо	Хөнгөлөлт чөлөөлөлтийн дүн /мян.төг/	Ажилгүйдлийн даатгалын сангаас олгосон дэмжлэг /мян .төг /
Ажил олгогчийн мэдээлэл	2020	680	3341	2,347,331.7	
	2021	696	3364	480,642.3	
	2020	108	1188		237,600.0
Сайн дурын даатгуулагч	2020		4913	1,679,838.3	
	2021		3951	473,042.8	
Дүн		1484	16757	4,980,855.2	237,600.0

Эх сурвалж: Нийгмийн даатгалын хэлтэс

Улсын Их Хурлын 2020 оны 21 дүгээр тогтоолын хүрээнд давхардсан тоогоор 1484 ажил олгогч, 16757 даатгуулагч хамрагдсан байна. Үүнээс 1376 ажил олгогчийн 6705 даатгуулагч, сайн дурын 8864 даатгуулагч, нийт 15569 даатгуулагчид 4,980,855.2 мянган төгрөгийн нийгмийн даатгалын шимтгэлийн хөнгөлөлт, чөлөөлөлт үзүүлсэн байна. Түүнчлэн 108 ажил олгогчийн 1188 даатгуулагчид 237,600.0 мянган төгрөгийн дэмжлэг олгосон байна.

8.3. Цар тахлын үеийн сөрөг нөлөөллөөс зорилтот бүлгийн хөдөлмөр эрхлэлт, ажлын байрыг хамгаалахаар хэрэгжүүлж буй арга хэмжээний үр дүнд хяналт тавиагүй байна.

МУЗГ-ын 2021 оны 42 дугаар тогтоолоор баталсан “Эрүүл мэндээ хамгаалж,

эдийн засгаа сэргээх 10 их наядын цогц төлөвлөгөө"-ний 2.5-д "Хөдөө аж ахуйн салбарт хаврын тариалалт, ноолуур, ноос, арьс шир бэлтгэл болон малчдын үйл ажиллагааг дэмжсэн хөнгөлөлттэй зээлийг Хөгжлийн банк, арилжааны банкуудын эх үүсвэрт тулгуурлан санхүүжүүлэх" гэж заасан байна. Тус тогтоолыг хэрэгжүүлэх үүднээс "Ажлын байрыг дэмжих зээл"-ийн санхүүжилтийн ерөнхий гэрээг Сангийн сайд, Монгол банкны ерөнхийлөгч, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд, Зээлийн батлан даалтын сангийн гүйцэтгэх захирал, арилжааны 10 банкны гүйцэтгэх захиралтай байгуулсан байна.

Орон нутагт ажлын байрыг дэмжих зээлийг гэрээ байгуулсан 4 арилжааны банкаар дамжуулан ААН, иргэдэд олгосон байна.

Хүснэгт 33 /сая.төг/

2022 оны 04 дүгээр сарын 08-ны өдрийн байдлаар

Д/д	Үзүүлэлт	Төрийн банк		Хаан банк		Хас банк		Голомт банк		Дүн	
		Зээлдэг чийн тоо	Зээлийн дүн								
1	ААН	34	5,441.0	33	5,909.7	11	2,178.4	24	5,165.7	102	18,694.8
2	Иргэн	857	16,588.7	1229	16,150.3	94	2,818.1	16	410.0	2196	35,967.1
	Дүн	891	22,029.7	1262	22,060.0	105	4,996.5	40	5,575.7	2298	54,661.9

Эх сурвалж: Арилжааны банкууд

Аймгийн хэмжээнд 102 аж ахуйн нэгжид 18,694.8 сая, 2196 иргэнд 35,967.1 сая, нийт 2298 ААН, иргэнд 54,661.9 сая төгрөгийн хөнгөлөлттэй зээл олгосон байна.

Зээлд хамрагдсан ААН, иргэний мэдээллийг арилжааны банкуудаас авч ажлын байрыг баталгаажуулахын тулд 2020, 2021 оны нийгмийн даатгалын шимтгэл төлсөн байдлыг тулгаж үзэхэд дараах байдалтай байна.

Хүснэгт 34

төрөл	Нийт зээл авсан	НДШ төслөн	НДШ төлөөгүй	НДШ төлөлтийн хувь
ААН	103	95	8	92.2
Иргэн	2196	1013	1183	46.1

Эх сурвалж: Нийгмийн даатгалын хэлтэс

Хөнгөлөлттэй зээл авсан ААН-ийн 92.2%, иргэний 46.1% шимтгэл төлсөн байна.

НДШ төлсөн иргэдийн шимтгэл төлөлтийн төрлийг авч үзвэл дараах байдалтай байна.

Хүснэгт 35

НДШ төлөлтийн төрөл	Хүний тоо	Авсан зээлийн дүн /сая.төг/
Төрийн албан хаагчаар	202	3,128.8
ААН-ээс	283	7,571.8
Сайн дур	528	8,959.1
Нийт	1013	19,659.7

Эх сурвалж: Нийгмийн даатгалын хэлтэс

Хөнгөлөлттэй зээл авсан иргэдийн 46.1 хувь нь НДШ төлж байгаагаас харахад үр дүн төдийлөн хангалтгүй байна. Түүнчлэн 202 төрийн албан хаагч 3.128.8 сая төгрөгийн зээл авсан нь ажлын байрыг дэмжих үндсэн зорилгодоо бүрэн нийцээгүй байна.

Эдгээр 202 төрийн албан хаагчаас 182 нь 2020, 2021 онд 6 сараас дээш хугацаагаар төрийн албан хаагчаар шимтгэл төлсөн ба нийт авсан зээлийн хэмжээ нь 2,885.3 сая төгрөг байна.

Тус зээлийн хэрэгжилтэд хэн хяналт тавих талаар тогтоолд заагаагүй байна. Аймгийн ХХҮГ нь зээлийн үр дүнд хяналт тавихын тулд мэдээлэл авахаар арилжааны банканд хандсан боловч нууц гэдэг үндэслэлээр мэдээлэл өгөөгүй байна. Цаашид зээлийн үр дүнд хяналт тавих субъектийг тодорхой болгох зүй ёсны шаардлага үүсэж байна. Иймд тус асуудлыг нэгдсэн тайланд тусгуулж холбогдох газруудад зөвлөмж чиглэл хүргүүлэх саналтай байна.

МУЗГ-ын 2021 оны 42 дугаар тогтоолоор баталсан “Эрүүл мэндээ хамгаалж, эдийн засгаа сэргээх 10 их наядын цогц төлөвлөгөө”-ний 2.6-д “Залуучуудын хөгжил, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих зорилгоор ажил мэргэжлийн чиг баримжаа олгох, хувь хүний хөгжлийн цогц сургалтын хөтөлбөр боловсруулан, залуучуудыг хамруулж хөдөлмөрт бэлтгэх, ажлын байраар хангахад дэмжлэг үзүүлэх” гэж заасны дагуу залуучуудыг хөдөлмөрт бэлтгэх, ажил мэргэжлийн чиг баримжаа олгох “Оролцоо” төслийг ХХҮЕГ-аас санхүүжүүлж хэрэгжүүлсэн байна.

Залуучуудыг хөдөлмөрт бэлтгэх, ажил мэргэжлийн чиг баримжаа олгох “Оролцоо төсөл”-д аймгийн хэмжээнд 330 залуучуудыг бүртгэж тэдгээрээс 118 нь төсөлд хамрагдсан байна.

Төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуй нэгжийн төлөөлөл нийт 45 байгууллагатай хамтран төсөлд хамрагдсан залуучуудыг ажлын байран дээр дадлагажуулах арга хэмжээг зохион байгуулж 115 залуучуудыг хамруулжээ.

Сургалтад хамрагдсан 70 иргэнийг байнгын болон түр ажлын байранд зуучилж ажилласан байна.

8.4. Цар тахлын улмаас хөдөлмөр эрхлэлтийн салбарт гарсан өөрчлөлт, статистик тоо мэдээг үнэн бодитой гаргасан байна.

Цар тахал гарахаас өмнөх болон цар тахлын жилүүдийн ААН-ийн тоог хүснэгтээр харуулбал дараах байдалтай байна. /Жич:Төсвийн байгууллага ороогүй/

Хүснэгт 36

Он	Нийт ААН-ийн тоо	Шинээр нэмэгдсэн ААН	Татан буугдсан ААН
2019.12.31	1905	19	20
2020.12.31	2015	128	18
2021.12.31	2144	156	27
Дүн		303	65

Эх сурвалж: Улсын бүртгэлийн хэлтэс

Улсын бүртгэлд 2019-2021 онд шинээр 303 ААН бүртгүүлж, 65 ААН татан буугдаж, нийт дүнгээрээ 239 ААН нэгж нэмэгдсэн байна.

Цар тахал гарахаас өмнөх болон хойно НДШ төлөгч ААН-ийн тоо, даатгуулагчийн тоо, сайн дурын даатгуулагчийн тоог хүснэгтээр харуулбал дараах байдалтай байна. /Жич:Төсвийн байгууллага болон төрийн албан хаагчид ороогүй/

Хүснэгт 37

	Он	Ажил олгогч ААН-ийн тоо	Даатгуулагчийн тоо
Ажил олгогчийн мэдээлэл	2019.12.31	764	4345
	2020.12.31	783	4312
	2021.12.31	807	4411
Нийт дүн		2354	13068
	2019.12.31		4569

Сайн дурын даатгуулагч	2020.12.31		5234
	2021.12.31		6246
Нийт дүн			16049

Эх сурвалж: Нийгмийн даатгалын хэлтэс

Цар тахал гарсан жилүүдэд НДШ төлөгч ААН, даатгуулагчийн тоо, сайн дурын даатгуулагчийн тоо өссөн үзүүлэлттэй байна.

Цар тахал гарахаас өмнөх болон цар тахал гарсан жилүүдийн ААНОАТ төлөгч болон үйл ажиллагааны орлого бүхий ХХОАТ төлөгчийн тоог хүснэгтээр харуулбал дараах байдалтай байна. /Жич:Төсвийн байгууллага болон төрийн албан хаагчид ороогүй./

Хүснэгт 38

Хугацаа	ААНОАТ төлөгчдийн тоо			Дүн	ХХОАТ төлөгчдийн тоо			Дүн
	2019	2020	2021		2019	2020	2021	
Оны эхэнд	1471	1581	1880	4932	1156	2608	2688	6452
Нэмэгдсэн	119	457	174	750	1467	110	50	1627
Хасагдсан	9	158	10	177	15	30	20	65
Оны эцэст	1581	1880	2044	5505	2608	2688	2718	8014

Эх сурвалж: Татварын хэлтэс

Цар тахлын жилүүдэд ААНОАТ төлөгчдийн тоо болон үйл ажиллагааны орлого бүхий ХХОАТ төлөгчдийн тоо өссөн үзүүлэлттэй байна. Цар тахлын жилүүдэд ААНОАТ төлөгчөөс 177 ААН хасагдаж, 750 ААН нэмэгдсэн байна. Үйл ажиллагааны орлого бүхий ХХОАТ төлөгчдөөс 65 иргэн хасагдаж, 1627 иргэн шинээр нэмэгдсэн байна.

ДҮГНЭЛТ

Энэхүү гүйцэтгэлийн аудитын явцад олж цуглуулсан нотлох зүйлс, баримт материал, судалгаа шинжилгээнд тулгуурлан дараах дүгнэлтийг хийж байна. Үүнд:

1. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэх чиглэлээр төрөөс хэрэгжүүлж буй хөтөлбөрүүд нь орон нутгийн дунд хугацааны тогтвортой хөгжлийн бодлоготой уялдсан байна.
2. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэх бодлогыг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийн эх үүсвэрийг үндэслэлтэй төлөвлөсөн байна.
3. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих салбарын төрийн байгууллагуудын чиг үүрэг харилцан уялдаатай байна.
4. Хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээнд хамаарах үйл ажиллагаа зохих үр нөлөөтэй байгаа ч “Нэгдсэн бүртгэл, мэдээллийн систем”-ийн зарим модуль ажиллахгүй, мэдээлэл боловсруулалт удаан байна.
5. Засгийн газраас хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажилгүйдлийг бууруулах, ажлын байр нэмэгдүүлэх чиглэлээр хэрэгжүүлсэн арга хэмжээ зохих үр нөлөөтэй байна.
6. ХЭҮЗ-ийн тогтоолд зааснаар 2021 онд гэрээт малчныг зөвхөн Улаанбаатар хотоос, 2022 онд Улаанбаатар хот болон аймгийн төвөөс хөдөөд шилжин суурьшсан иргэнээс сонгох шаардлагатай болсноор тус хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд бэрхшээл тулгарч байна.
7. 2020 оноос эхлэн эргэн төлөгдөх нөхцөлтэй санхүүгийн дэмжлэг олгохдоо нийгмийн даатгалын шимтгэл төлдөг батлан даагчтай байх шаардлагыг ХХҮЕГ-аас тавьж байна.
8. Эргэн төлөгдөх нөхцөлтэй санхүүгийн дэмжлэг олгохдоо гүйцэтгэлийн тайланг шууд авсан байна.
9. Төсөл, хөтөлбөрийн хэрэгжилт, санхүүжилт, үр дүнг бодитой тайлагнаж, үнэлсэн байна.
10. Хөгжлийн бэрхшээлтэй хүнийг ажиллуулаагүй аж ахуйн нэгж, байгууллагаас төлөх төлбөрийг 2018-2021 онд төвлөрүүлээгүй байна.
11. 2021 оны жилийн эцсийн байдлаар 1,728.0 сая төгрөгийн авлагатай байгаагаас 392.1 сая төгрөгийн эргэн төлөлтийн хугацаа хэтэрсэн байна.
12. ХЭҮЗ-ийн тогтоолоор баталсан хөтөлбөрт хамрагдахад тавигдах шаардлагыг хангаагүй 6 иргэнд эргэн төлөгдөх нөхцөлтэй санхүүгийн дэмжлэг олгосон байна.
13. "Ковид-19" цар тахлын үед хөдөлмөр эрхлэлтийн талаар төрөөс авч хэрэгжүүлсэн арга хэмжээ зохих үр дүнтэй байна.
14. Улаангом политехник коллеж хөдөлмөрт бэлтгэх үйл ажиллагааг үр нөлөөтэй хэрэгжүүлсэн байна.
15. Цар тахлын үеийн сөрөг нөлөөллөөс зорилтот бүлгийн хөдөлмөр эрхлэлт, ажлын байрыг хамгаалахаар хэрэгжүүлж буй арга хэмжээний үр дүнд хяналт тавиагүй байна.

Холбогдох байгууллагын санал



МОНГОЛ УЛС
УВС АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА

3 дугаар баг, Улаангом, Увс аймаг, 85165

Утас: 7045-2315, Факс: 7045-4095

Цахим шуудан: info@uvs.gov.mn

Цахим хуудас: www.uvs.gov.mn

2022. 05. 04 № 1/774

танай _____ -ны № _____ -т

ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАРТ

Төрөөс хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэх чиглэлээр авч хэрэгжүүлсэн бодлогын хэрэгжилт, үр дүнд хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлангийн төсөлтэй танилцаад бусад санал зөвлөмжийг дэмжиж байгаа ба Үндэсний аудитын газар уламжлах санал, зөвлөмжид дараах арга хэмжээнүүдийг тусгах саналыг хүргүүлж байна. Үүнд:


1. Орон нутгийн онцлогт тохирсон төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэхэд ХНХЯ-аас санхүүгийн дэмжлэг үзүүлэх
2. Хувиараа хөдөлмөр эрхлэх хүсэлтэй эмэгтэйчүүдэд зориулсан санхүүгийн дэмжлэгт зарцуулах хөрөнгийн хэмжээг нэмэгдүүлэх
3. ХЭДС-ийн санхүүжилтийг батлагдсан төсвийн дүнгээр аймагт хуваарилан ирүүлж байх
4. Залуучуудын гарааны бизнесийг дэмжих "Start-up" хөтөлбөрийн санхүүжилтыг нэмэгдүүлж, олон залуучууд хамрагдах нөхцөлийг бүрдүүлэх



Ч.ЧИМЭД

Диск: AZDTG- zasag A-5

8522020426



8522140366

D.2022 on alban toot A5.5 sar

Холбогдох байгууллагын саналд өгсөн тайлбар

Увс аймгийн Засаг дарга: “Төрөөс хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэх чиглэлээр авч хэрэгжүүлсэн бодлогын хэрэгжилт, үр дүнд хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлангийн төсөлтэй танилцаад бусад санал зөвлөмжийг дэмжиж байгаа ба Үндэсний аудитын газар уламжлах санал, зөвлөмжид дараах арга хэмжээнүүдийг тусгах саналыг хүргүүлж байна. Үүнд:

1. Орон нутгийн онцлогт тохирсон төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэхэд ХНХЯ-аас санхүүгийн дэмжлэг үзүүлэх
2. Хувиараа хөдөлмөр эрхлэх хүсэлтэй эмэгтэйчүүдэд зориулсан санхүүгийн дэмжлэгт зарцуулах хөрөнгийн хэмжээг нэмэгдүүлэх
3. ХЭДС-ийн санхүүжилтийг батлагдсан төсвийн дүнгээр аймагт хуваарилан ирүүлж байх
4. Залуучуудын гарааны бизнесийг дэмжих “Start-up” хөтөлбөрийн санхүүжилтийг нэмэгдүүлж, олон залуучууд хамрагдах нөхцөлийг бүрдүүлэх” гэсэн санал ирүүлсэн байна.

Хариу: Тайлбар өгөх шаардлагагүй гэж үзлээ. ҮАГ-т уламжилж нэгдсэн тайланд тусгуулах санал ирүүлснийг аудитын тайлантай хамт хүргүүллээ.

Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар: “Төрөөс хөдөлмөр эрхлэлтийг дэмжих чиглэлээр 2016-2021 онуудад хэрэгжүүлсэн төсөл, хөтөлбөрүүдийн бодлогын хэрэгжилтэд гүйцэтгэлийн аудит хийж тайлангийн төсөл ирүүлсэнтэй санал нэг байна. Цаашид аудитын байгууллагаас өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллах болно” гэсэн санал ирүүлсэн байна.

Хариу: Тайлбар өгөх шаардлагагүй гэж үзлээ.

ЗӨВЛӨМЖ

Аудитын дүн дүгнэлтэд үндэслэн дор дурдсан арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг зөвлөмж болгож байна. Үүнд:

Увс аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газарт:

1. Санхүүгийн дэмжлэг олгохдоо гүйцэтгэлийн тайланг шууд авахгүй, тодорхой хугацааны дараа үр дүн гарахаар нь авч байх.
2. Хөгжлийн бэрхшээлтэй хүнийг ажиллуулаагүй аж ахуйн нэгж, байгууллагаас төлөх төлбөрийг төвлөрүүлэх.
3. Авлагыг барагдуулах чиглэлээр тодорхой арга хэмжээ авч ажиллах.
4. Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн тогтоолоор баталсан хөтөлбөрт хамрагдахад тавигдах шаардлагыг мөрдөж ажиллах

Үндэсний аудитын газарт уламжлах санал:

Дараах асуудлуудыг УАГ-ын нэгдсэн тайланд тусгуулж холбогдох газруудад зөвлөмж чиглэл хүргүүлэх саналтай байна.

1. Хөдөлмөрийн зах зээлийн мэдээллийн нэгдсэн систем “LMIS” программын мэдээлэл боловсруулалт удаан, зарим модуль ажиллахгүй байгаа тул зайлшгүй шинэчилж сайжруулах шаардлага үүсэж байна.
2. ХЭҮЗ-ийн тогтоолд зааснаар 2021 онд гэрээт малчныг зөвхөн Улаанбаатар хотоос, 2022 онд Улаанбаатар хот болон аймгийн төвөөс хөдөөд шилжин суурьшсан иргэнээс сонгох шаардлагатай болсон нь тус хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд бэрхшээл тулгарч байна. Өөрөөр хэлбэл Улаанбаатар хот болон аймгийн төвөөс хөдөө суманд мал маллах иргэн төдийлөн байдаггүй байна. Иймд ХЭҮЗ-ийн тогтоолд сумын төвөөс хөдөө багт, сумаас сум хооронд гэрээт малчнаар ажиллах боломжийг тусгуулах.
3. 2020 оноос эхлэн эргэн төлөгдөх нөхцөлтэй санхүүгийн дэмжлэг олгохдоо нийгмийн даатгалын шимтгэл төлдөг батлан даагчтай байх шаардлагыг ХХҮЕГ-аас тавьж 2020 оны А/61 дүгээр тушаалаар баталсан гэрээний загварт тусгаж ирүүлснийг аймгийн ХХҮГ хэрэгжүүлэн ажиллаж байна. Ингэснээр гарч болох бүх эрсдэлийг батлан даагч давхар хариуцахаар үүрэг хүлээж санхүүгийн дэмжлэгийн эргэн төлөлт сайжрах нь төрийн байгууллага талдаа үр ашигтай боловч иргэн санхүүгийн дэмжлэгт хамрагдахын тулд гэр бүлийн аль нэг гишүүн нь нийгмийн даатгалын шимтгэл төлдөггүй тохиолдолд гуравдагч этгээдээр батлан даалгахаас өөр аргагүй нөхцөл байдал үүсэж байна. Өөрөөр хэлбэл гэр бүлийн гишүүд хөдөлмөр эрхэлдэггүй тохиолдолд санхүүгийн дэмжлэгт хамрагдахад бэрхшээл үүсэж байгаа нь төслийн үндсэн зорилготойгоо зөрчилдөж байна. Түүнчлэн хууль, тогтоомж, ХЭҮЗ-ийн тогтоолд заагдаагүй “батлан даагч нь заавал нийгмийн даатгалын шимтгэл

төлөгч байна” гэсэн нэмэлт шаардлагыг ХХҮЕГ-аас тавьж байгаа асуудлыг шийдвэрлэх.

4. Эргэн төлөх нөхцөлтэй санхүүгийн дэмжлэгт хамрагдаж байгаа иргэдийн мэдээллийг Монгол банкны зээлийн мэдээллийн санд оруулах.
5. МУЗГ-ын 2021 оны 42 дугаар тогтоолоор баталсан “Эрүүл мэндээ хамгаалж, эдийн засгаа сэргээх 10 их наядын цогц төлөвлөгөө”-д заасны дагуу олгогдсон Хөдөө аж ахуйн салбарт хаврын тариалалт, ноолуур, ноос, арьс шир бэлтгэл болон малчдын үйл ажиллагааг дэмжсэн хөнгөлөлттэй зээлийн үр дүнд хяналт тавих субъектийг тодорхой болгох.
6. Аймгийн Засаг даргаас 2022 оны 1/774 дүгээр албан бичгээр ҮАГ-т уламжилж нэгдсэн тайланд тусгуулах санал ирүүлснийг аудитын тайлантай хамт хүргүүллээ.



ХЯНАСАН:

АУДИТЫН МЕНЕЖЕР

БЭЛТГЭСЭН:

АХЛАХ АУДИТОР

АУДИТОР

АУДИТОР

/ М.БАТ-АМГАЛАН /

/ Б.АВИРМЭД /

/ А.НАНЖИДМАА /

/ Р.АЮУШ /



Увс аймаг

№	Төсөл, хөтөлбөрийн нэр	Зорилт	Шалгуур үзүүлэлт
1		3	4
1	Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөх үйлчилгээг дэмжих хөтөлбөр	Төгсөх ангийн хүүхдүүдэд мэргэжлээ зөв сонгоход зөвлөх, ажилгүй иргэдэд зөвлөгөө мэдээлэл өгч дахин мэргэжил эзэмшин хөдөлмөрлөх чиг хандлагыг бий болгох	Ерөнхий боловсролын 9,12 дугаар анги төгсөгч нар, Ажил хайгч ажилгүй иргэд
2	Аж ахуй эрхлэх, бичил бизнесийг дэмжих хөтөлбөр	Хувиараа болон нөхөрлөл, хоршоо байгуулах хүсэлтэй эрхлэгч иргэдийг санхүүгийн дэмжлэгт хамруулах, борлуулалтын болон түрээсийн дэмжлэг үзүүлэх, жижиг зээл олгож байнгын ажлын байраар хангах, ажилгүй иргэдийг улирлын ажлын байраар хангах	35-аас дээш насны хувиараа хөдөлмөр эрхлэгч, Ажилгүй иргэн, ур чадвартай ахмад мэргэжилтэн, Нөхөрлөл хоршоо
3	Хөдөлмөр эрхлэлтийн ур чадвар олгох, ажлын байрыг дэмжих хөтөлбөр	Хөдөлмөрт бэлтгэх, ажилд зуучлах, хөдөлмөр эрхлэлтийн сургалтад хамруулах, ажил олгогчийг дэмжих, ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээ үзүүлэх	Ажил олоход хүндрэлтэй иргэн, ажил хайгч иргэн, хувиараа хөдөлмөр эрхлэгч иргэн
4	Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр	МБСБ төгсөгчдөд гарааны дэмжлэг үзүүлэх, ажилд зуучлах, Нийтийг хамарсан ажилд хамруулах, борлуулалтын болон түрээсийн дэмжлэг үзүүлэх, сургалтад хамруулан мэргэжилтэй болгож түр болон байнгын ажлын байраар хангах	25 хүртэлх насны залуучууд, 15-34 хүртэлх насны ажилгүй, ажил хийхэд бэлэн, ажил идэвхтэй хайж байгаа/ санхүүгийн дэмжлэг 10 хүртэлх сая эргэн төлөх нөхцөлгүй/ залуучууд, их дээд сургууль, мэргэжлийн боловсролын сургууль төгсөөд 3 жил болж байгаа мэргэжлээрээ ажилласан туршлагагүй ажил хайж байгаа залуучууд
5	Хөгжлийн бэрхшээлтэй иргэний ажлын байрыг дэмжих хөтөлбөр	ХБИ-ийг ажлын байраар хангаж, ажил олгогчид санхүүгийн дэмжлэг үзүүлэн ажлын байрны хадгалалтыг нэмэгдүүлэх	Хөдөлмөр мегадлах комиссын шийдвэртэй ХБИ, Байнгын асаргаанд байдаг хөгжлийн бэрхшээлтэй хүүхдээ асарч буй эцэг, эх, хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг байнгын ажлын байраар хангаж буй ажил олгогч
6	Малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр	Малжуулах, тоног төхөөрөмжийн дэмжлэг үзүүлэх, сургалтад хамруулах	Малын тоо толгой, өрхийн 2 гишүүний нас
7	Нийтийг хамарсан ажил зохион байгуулах хөтөлбөр	Ажилгүй иргэдийг түр ажлын байраар хангаж өрхийн орлогыг нэмэгдүүлэх	Ажилгүй ажил хайгч иргэд
8	Ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээний төсөл	Ур чадвартай ахмадын зөвлөгөөг хойч үед өвлүүлэх	тухайн салбарт 3-аас дээш жил ажилласан байх
9	Хөдөлмөрт бэлтгэх, хөдөлмөр эрхлэлтийн ур чадвар олгох хөтөлбөр	Хөдөлмөрт бэлтгэх арга хэмжээ, мэргэжлийн болон давтан сургалт, үйлдвэрлэл дээрх сургалт зохион байгуулан	Ажилгүй иргэн, ажилгүйдэлд өртөж болзошгүй иргэн, ажил олоход хүндрэлтэй иргэн, сургууль завсардсан хөдөлмөрийн насны хүүхэд, 15-34 насны залуучууд
10	Ажлын байрыг дэмжих хөтөлбөр	Хувиараа болон нөхөрлөл хоршооны хэлбэрээр бизнес эрхлэн үйлдвэрлэл үйлчилгээ эрхлэгчдэд санхүүгийн дэмжлэг олгон байнгын ажлын байртай болгох, Ажлын байрны хадгалалтыг сайжруулан ажил олгогч нарт урамшуулал олгох, Ажилгүй, ажил хайгч иргэдийг түр ажлын байраар ханган өрхийн орлогыг нэмэгдүүлэх	35-аас дээш насны хувиараа хөдөлмөр эрхлэгч иргэн, ажил хайгч ажилгүй иргэн

Төрөөс хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэх чиглэлээр авч хэрэгжүүлсэн төсөл, хөтөлбөрийн судалгаа

2015 он				2016 он				2017 он				2018 он	
Батлагдсан төсөв /сая төгрөг/	Төсвийн гүйцэтгэл /сая төгрөг/	Зөрүү /сая төгрөг/	Төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтийн хувь	Батлагдсан төсөв /сая төгрөг/	Төсвийн гүйцэтгэл /сая төгрөг/	Зөрүү /сая төгрөг/	Төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтийн хувь	Батлагдсан төсөв /сая төгрөг/	Төсвийн гүйцэтгэл /сая төгрөг/	Зөрүү /сая төгрөг/	Төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтийн хувь	Батлагдсан төсөв /сая төгрөг/	Төсвийн гүйцэтгэл /сая төгрөг/
5	6	7	8	9	10	11	12	13	14	15	16	17	18
				14.8	14.5	0.2	99.0						
193.5	178.4	15.1	87.0	184.5	140.7	43.8	86.0						
190.4	171.0	19.4	95.0	168.4	129.2	39.2	88.0						
138.7	39.6	99.1	40.0	50.0	35.4	14.6	90.0						
				82.2	54.7	27.5	69.0	116.7	63.4	53.3	60.0	79.9	63.0
451.1	376.0	75.1	92.0	322.0	285.1	36.9	92.0	209.0	204.8	4.2	100.0	315.0	310.1
88.0	87.9	0.1	100.0	105.6	71.7	33.9	91.0			-			
				16.0	11.6	4.4	73.0			-			
						-		41.3	37.3	4.0	95.0	34.6	29.7
						-		388.5	347.6	40.9	93.0	354.6	334.8

Он	2019 он				2020 он				2021 он				
	Төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтийн хувь	Батлагдсан төсөв /сая төгрөг/	Төсвийн гүйцэтгэл /сая төгрөг/	Зөрүү /сая төгрөг/	Төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтийн хувь	Батлагдсан төсөв /сая төгрөг/	Төсвийн гүйцэтгэл /сая төгрөг/	Зөрүү /сая төгрөг/	Төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтийн хувь	Батлагдсан төсөв /сая төгрөг/	Төсвийн гүйцэтгэл /сая төгрөг/	Зөрүү /сая төгрөг/	Төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтийн хувь
19	20	21	22	23	24	25	26	27	28	29	30	31	32
-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
16.9	73.0	73.9	62.0	11.9	93.0	85.5	70.5	15.0	93.5	18.4	14.4	4.0	89.0
4.9	99.0	346.5	312.3	34.2	97.0	238.0	234.0	4.0	99.4	-	-	-	-
-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
4.9	93.0	34.6	21.0	13.6	57.0	2.3	2.3	-	100.0	-	-	-	-
19.8	95.0	468.9	400.5	68.4	95.0	475.8	343.5	132.2	86.4	-	-	-	-

/Сая төгрөг/

Төсөв /сая төгрөг/	Санхүүжилтийн эх үүсвэр		Нийт дүн /сая төгрөг/	Хамрагдсан ан иргэдийн тоо	Нэмэгдсэн ажлын байрны тоо		Хариуцах байгууллага	Хяналт, шинжилгээ хийсэн эсэх	АНЗД-ын 2016- 2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрт туссан эсэх	Дэд хөтөлбөрт туссан эсэх	Аймаг, нийслэлийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх 2016-2020 оны үндсэн чиглэлийн төлөвлөгөөнд туссан эсэх	Олон нийтийн оролцоо, ил тод байдал хангагдсан эсэх	Тайлбар, тодруулга
	Зээл, тусламж /сая төгрөг/	Бусад /сая төгрөг/			Байнгын /6 сараас дээш/	Тур /6 сараас доош/							
33	34	35	36	37	38	39	40	41	42	43	44	45	46
14.5			14.5	1230	730		ХХҮГазар	Тийм	Тийм		Тийм	Тийм	
319.1			319.1	502	150	70	ХХҮГазар	Тийм	Тийм		Тийм	Тийм	
300.2			300.2	452	83		ХХҮГазар	Тийм	Тийм		Тийм	Тийм	
89.3			89.3	192	39	50	ХХҮГазар	Тийм	Тийм		Тийм	Тийм	
313.6			313.6	421	178	1	ХХҮГазар	Тийм	Тийм		Тийм	Тийм	
1,722.3			1,722.3	1624	901		ХХҮГазар	Тийм	Тийм		Тийм	Тийм	
159.6			159.6	1051		1051	ХХҮГазар	Тийм	Тийм		Тийм	Тийм	
11.6			11.6	58		58	ХХҮГазар	Тийм	Тийм		Тийм	Тийм	
90.3			90.3	1009			ХХҮГазар	Тийм	Тийм		Тийм	Тийм	
1,426.5			1,426.5	3307	268	2529	ХХҮГазар	Тийм	Тийм		Тийм	Тийм	

11	Залуучуудын хөдөлмөр эрхлэлт, гарааны бизнесийг дэмжих хөтөлбөр	Гарааны бизнесийг дэмжих, санхүүгийн дэмжлэг олгох, борлуулалтын болон түрээсийн дэмжлэг үзүүлэх	15-34 хүртэлх насны ажилгүй, ажил хийхэд бэлэн, ажил идэвхтэй хайж байгаа залуучууд / санхүүгийн дэмжлэг 2017 онд 24 сарын хугацаатай эргэн төлөх нөхцөлтэй, 2018-2020 онд 36 сарын хугацаатай эргэн төлөх нөхцөлтэй/
12	Ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээг хөгжүүлэх хөтөлбөр	Ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээ үзүүлэн ажлын арга туршлагыг өвлүүлэн үлдээх, зөвлөн туслах, ахмадын хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх	эрүүл мэнд, боловсрол, хөдөө аж ахуй болон төрийн захиргаа гэсэн салбарт ажиллаж байгаад өндөр насны тэтгэвэр гарсан ахмад, Хувиараа хөдөлмөр эрхлэгч ахмад
13	Хөдөлмөрт бэлтгэх хөтөлбөр	Зорилгот бүлгийн иргэдэд ажил мэргэжлийн чиг баримжаа олгох, сургалт арга зүйгээр хангаж ажилд зуучлах	Ажилгүй иргэн, ажилгүйдэлд өртөж болзошгүй иргэн, ажил олоход хүндрэлтэй иргэн, хорих ангиас суллагдсан иргэн, сургууль завсардсан хөдөлмөрийн насны хүүхэд
14	Цар тахлын үед аж ахуй эрхлэгчдийн үйл ажиллагааг сэргээх хөтөлбөр	Хувиараа хөдөлмөр эрхлэгч иргэн болон цөөн малтай малтай иргэдэд санхүүгийн дэмжлэг олгон байнгын ажлын байртай болгох, Ажлын байрны хэдгэлэлтийг сайжруулан ажил олгогч нарт урамшуулал олгох, Ажилгүй, ажил хайгч иргэдийг түр ажлын байраар ханган өрхийн орлогыг нэмэгдүүлэх эдгээр иргэдэд аж ахуй эрхлэлтийн сургалт зохион байгуулж ур чадварыг нэмэгдүүлэх	Бичил үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгч, нөхөрлөл, хоршоо хэлбэрээр үйлдвэрлэл үйлчилгээ эрхлэгч, хувиараа хөдөлмөр эрхлэгч, гадаад улсад ажиллаж байгаад ирсэн иргэн / санхүүгийн дэмжлэг 35-аас дээш насны 5 хүртэлх сая төгрөг, 36 сарын хугацаатай, эргэн төлөх нөхцөлтэй/ малгүй, цөөн малтай, өрхийн 2 гишүүн 18-45 насны, 150 хүртэлх толгой бог малтай бол 5.0 сая, 150-200 хүртэлх толгой бог малтай бол 4.0 хүртэлх сая төгрөгөөр малжуулах, эргэн төлөх нөхцөлтэй/
15	Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр	Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд ажил мэргэжлийн чиг баримжаа олгох, сургалт арга зүйгээр хангаж ажилд зуучлах, Санхүүгийн дэмжлэг олгон байнгын ажлын байраар хангах, аж ахуй эрхлэлтийн сургалт зохион байгуулж ур чадварыг нэмэгдүүлэх	Хөдөлмөр магадлах комиссын шийдвэртэй ХБИ, Байнгын асаргаанд байдаг хөгжлийн бэрхшээлтэй хүүхдээ асарч буй эцэг, эх /санхүүгийн дэмжлэг 3.0-5.0 сая, 36 сарын хугацаанд 50% эргэн төлөх нөхцөлтэй/ хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг байнгын ажлын байраар хангаж буй ажил олгогч
16	Ахмадын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр	Ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээ үзүүлэн ажлын арга туршлагыг өвлүүлэн үлдээх, ахмадын хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх	Өндөр насны тэтгэвэрт гарсан ахмад настан, ахмадын төрийн бус байгууллага, аж ахуй өрхийн үйлдвэрлэл эрхэх зорилготой ахмад /зөвлөх үйлчилгээ 1 жил хүртэлх хугацаанд ажлын 30 өдөр, 240 цагаас хэтрэхгүй хугацаанд эрүүл мэнд, боловсрол, хөдөө аж ахуй болон төрийн захиргаа гэсэн салбарт ажлын хөлс цагийн-3500, санхүүгийн дэмжлэгийн хэмжээ 3 хүртэлх сая төгрөг эргэн төлөх нөхцөлтэй 24 сарын хугацаатай/
17	Залуучуудыг хөдөлмөрт бэлтгэх "Оролцоо" төсөл		
18	Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төсөл		
19	Ажилд зуучлах үйлчилгээ	Ажилгүй иргэдийг ажилд зуучлах	Ажилгүй иргэн, ажил хайгч иргэн
20	Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөх үйлчилгээ	Төгсөх ангийн хүүхдүүдэд мэргэжлээ зөв сонгоход зөвлөх, ажилгүй иргэдэд зөвлөгөө мэдээлэл өгч дахин мэргэжил зээмшин хөдөлмөрлөх чиг хандлагыг бий болгох	Ерөнхий боловсролын 9.12 дугаар анги төгсөгч нар, Ажил хайгч ажилгүй иргэд
21	Интерншип туршилтын хөтөлбөр	Ажлын байранд дадлагажуулан ажилд зуучлах	34 хүртэлх насны залуучууд
		ДҮН	

300.8			300.8	275	91	50	ХХУГазар	Тийм	Тийм		Тийм	Тийм	
141.2			141.2	116	31	85	ХХУГазар	Тийм	Тийм		Тийм	Тийм	
13.6			13.6	118			ХХУГазар	Тийм	Тийм		Тийм	Тийм	
413.8			413.8	903	105	580	ХХУГазар	Тийм	Тийм		Тийм	Тийм	
166.8			166.8	183	81		ХХУГазар	Тийм	Тийм		Тийм	Тийм	
39.0			39.0	48	9	39	ХХУГазар	Тийм	Тийм		Тийм	Тийм	
-			-	118	58		ХХУГазар	Тийм	Тийм		Тийм	Тийм	Санхүүжилт орон нутгаар дамжаагүй.
-			-				ХХУГазар	Тийм	Тийм		Тийм	Тийм	Санхүүжилт орон нутгаар дамжаагүй.
48.6			48.6	7859			ХХУГазар	Тийм	Тийм		Тийм	Тийм	
82.0			82.0	11703			ХХУГазар	Тийм	Тийм		Тийм	Тийм	
	12.3		12.3	15	15		ХХУГазар	Тийм	Тийм		Тийм	Тийм	
5652.7	12.3	0.0	5665.0	31169	2724	4513							



М.Бат-Амгалан
М.Батсуурь

Хянасан: Аудитын менежер
Дарга, тэргүүлэх аудитор

Б.Авирмэд
А.Нанжидмаа
Р.Аюуш

Бэлтгэсэн: Ахлах аудитор
Аудитор

Увс аймгийн ажил эрхэлдэггүй иргэдээс авсан санал, асуултын нөхцөлтэй

Д/д	Асуулт	Хариулт										Улаангом-1 баг	Улаангом-5 баг	Улаангом-9 баг	Улаангом-11 баг	Улаангом-12 баг	Улаангом-8 баг	
		А	Б	В	Г	Д	Е											
1	Таны оршин суугаа сум, дүүрэг	Улаангом 18	Улаангом-10 баг 2	Улаангом Чандмань 1	Улаангом-4 баг 8	Улаангом-11 баг 2	Улаангом-9 баг 2	Улаангом-1 баг 1	Улаангом-5 баг 2	Улаангом-9 баг 2	Улаангом-11 баг 2	Улаангом-12 баг 1	Улаангом-8 баг 1					
2	Таны нас	А. 18-25 6	Б. 26-34 17	В. 35-45 14	Г. 46-55 9	Д. 56-60 3	Е. 60-аас дээш 3											
3	Хүйс	А. Эрэгтэй 8	Б. Эмэгтэй 43															
4	Боловсролын түвшин	А. Бага 4	Б. Бүрэн дунд 32	В. Мэргэжлийн боловсрол, сургалт 6	Г. Дээд 9													
5	Та өмнө нь хөдөлмөр эрхэлж байсан уу?	Тийм бол																
		Төрийн байгууллага	ХАА-н салбарт	Аж үйлдвэр, уул уурхайн салбарт	Үйлчилгээний салбарт	Бусад	Үгүй											
6	Таны ажилгүй байгаа хугацаа?	А. 1-6 сар 17	Б. 7-12 сар 5	В. 1-3 жил 8	Г. 3 жилээс дээш 21													
7	Та ажил хайх ямар оролдлого хийсэн бэ? /1-ээс илүүг сонгож болно	Хөдөлмөрийн яариаг оролцох	Ажлын зарын дагуу холбогдох	Төрийн хөдөлмөр эрхэлтийн байгууллагад ажил хайгчаар бүртгүүлэх	Ажилд зуучлах хувийн байгууллагад ажил хайгчаар бүртгүүлэх	Боловсрол (сургалт)-ын байгууллагаар дамжуулан	Хувийн бизнес эхлүүлэх	Оролдлого хийгээгүй	Бусад (бичих)									
8	Та орон нутгийнхаа ажилгүй иргэдийн бүртгэлд бүртгүүлсэн үү?	Тийм																
		А. Гэр бүлийн гишүүдийн орлого	Хаана бүртгүүлэхэд мэдэхгүй	Бүртгүүлэх шаардлагагүй	Бусад													
9	Таны өрхийн сарын орлого ямар эх үүсвэрээс бүрддэг вэ?	А. 1-3 сар 17	Б. 3-6 сар 6	В. 6-12 сар 27	Г. 1 жилээс дээш 3	Д. Бусад 15	байхгүй											
11	Үйлчилгээнд хамрагдсанаар ямар хугацаагаар ажлын байраар хангагдаж байсан бэ?	А. 1-3 сар 12	Б. 3-6 сар 2	В. 6-12 сар 3	Г. 1 жилээс дээш 16	Д. Бусад 5	18											
12	Та төрөөс хэрэгжүүлж буй ажил эрхлэлтийг нэмэгдүүлэх, дэмжих арга хэмжээний талаарх мэдээллийг хаанаас авдаг вэ?	А. Баг, хороо 11	Б. Тандяг хүнээс 11	В. ТБ, радио 11	Г. Цахим орчин 19	Д. Мэдээлэл хангалтгүй 5												
13	Таны ажил хөдөлмөр эрхлэхгүй байгаа шалтгаан юу вэ?	Эрүүл мэндийн зсвал хөгжлийн бэрхшээл 6	Ар гэрийн байдлаас 7	Боловсрол эзэмшиж байгаа 3	КОВИД-19-ийн улмаас ажлын байргүй болсон 2	Ажилд орохор хүлээж байгаа 3	Тогихор ажил олдохгүй байгаа 9	Эзэмшсэн боловсрол амьдрал нийцэхгүй байх 3	Ажлын байрны амжиллах нөхцөл муу 3									
14	Таны оршин суугаа газарт ажлын байрны олгоц хэр байна вэ?	А. Сайн 9	Б. Дунд 16	В. Муу 25														
15	Та ажил, хөдөлмөр эрхлсэн боловч өөрт хамааралгүй шалтгааны улмаас цалингаа авч чадаагүй тохиолдол байгаа юу?	А. Тийм 8	Б. Үгүй 34															
16	Ажилд ороход ямар шаардлагыг тулхуу тавьдаг вэ? /1-ээс илүүг сонгож болно/	А. Боловсролын зэрэг 16	Б. Нас 11	В. Хүйс 3	Г. Гадаад дүр төрх 3	Д. Гадаад хэлний мэдлэг 3	Е. Ур чадвар 13	Ж. Бусад 11	Цалин бага 11	Хүйсийн ялгаа заасан байдаг 1	Төрийн албаны шаалгалтад хямагдаагүй 1	Бусад (бичих) 13						

10. Та хүснэгтэд дурдсан төрөөс хэрэгжүүлж буй дараах үйлчилгээгнүүдэд /хөтөлбөр/ хамрагдаж байсан уу?

А. Тийм Б. Үгүй

Тийм бол хүлээн авсан үйлчилгээнд хэр сэтгэл хангалуун байна вэ?

Үйлчилгээний төрөл	Тийм	Маш их сэтгэл хангалуун	Сэтгэл хангалуун	Аль нь ч биш	Сэтгэл хангалуун бус	Маш их сэтгэл дундуур	Үгүй
Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох	4	8	3	1			34
Мэргэжлийн сургалтын чиг баримжаа		4	3				
Зөвлөгөө	1	6	2				
Мэдээлэл	3	3	5		1		
Ажилд зуучлах	3	2	2	1	1		

Бэлтгэсэн: Ахлах аудитор

Аудитор

Хянасан: Аудитын менежер:

Баталгаажуулсан: Дарга, тэргүүлэх аудитор



 Б.Авирмэд
 А.Нанжидмаа
 А.Аюуш
 М.Бат-Амгалан
 М.Батсуурь

Огноо: 2022.05.04

Огноо: 2022.05.04

Огноо: 2022.05.04